НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН
ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНИЙ 2025 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2025 оны 12 дугаар сарын 03

Багахангай дүүрэг

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт				Хэрэгжилт хувь	ХШҮ хувь
		Зарцуулсан хөрөнгө (сая.төг)	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт, хувь (хүрээгүй бол тайлбар)		
Гурав. Дүүргийн Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.							
3.1.Хууль тогтоомжийн хүрээнд:							
1	Арга хэмжээ 3.1.1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлэх;	-	Хууль тогтоомжийн хэрэгжилт, хувь	90	**25.1.1.дүүргийн хөгжлийн үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлт, ерөнхий ба хэсэгчилсэн төлөвлөгөө;** "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Улаанбаатар 2040" хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал, "Улаанбаатар хотын 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага" зэрэг бодлогын баримт бичгүүдэд тус дүүргийг амьдрахад таатай, байгаль орчинд эелтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлэхээр төлөвлөсөн. Улс, нийслэлээс баримталж буй шийдвэрийн дагуу Багахангай дүүрэг нь орон нутгийн зэрэглэлтэй нийслэлийн дагуул хот болж хөгжихөөр тусгагдсан. Одоогоор дүүргийн нийт 14,000.0 га газраас төвийн 3,000.0 га газарт хийгдсэн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу хот төлөвлөлт, газар зохион байгуулалтын үйл ажиллагаа явагдаж байна. Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, нийслэлээс баримталж буй хөгжлийн бодлогын хүрээнд тус дүүрэг нь Багануур, Налайх дүүргүүдийн хамт улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотод шилжихтэй холбогдуулан Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгээс 2.000,0 төгрөгийн төсөвт өртгийг шийдвэрлэж, дүүргийн нутаг дэвсгэрийг бүрэн хамруулан, ТЭЗҮ хийх тендерийг зарлаж, гүйцэтгэгчээр Санхүү, эдийн засгийн их сургуулийн багш, судлаачдын баг шалгарч судалгааны ажлыг эхлүүлээд байна. Дээрх судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх хүрээнд дүүргийн Засаг даргын 2025 оны А/174 дүгээр захирамжаар 17 хүний бүрэлдэхүүнтэй Ажлын хэсгийг байгуулж, гишүүдэд холбогдох чиглэлийг өгөхөөр ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, гүйцэтгэгчээс ирүүлсэн судалгааны ажилд шаардлагатай баримт материалын жагсаалтын талаар танилцуулан холбогдох	100	100

					мэдээллийг хүргүүлсэн. Дүүргийн зүгээс Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлох зорилгоор судалгаа, зөвлөх үйлчилгээний ХХК-иар "БАГАХАНГАЙ 2040 ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР" бодлогын баримт бичгийг гүйцэтгүүлж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит XXV хуралдаанаар хэлэлцүүлэн, батлуулсан. Энэхүү баримт бичигт тусгагдсан ажил, арга хэмжээг төрөөс баримталж буй бодлого, шийдвэрүүдтэй уялдуулан зөв төлөвлөлт, үр дүнтэй байдлаар хэрэгжүүлэх, тогтоолд тусгагдсаны дагуу 2026 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтийг нэгтгэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд танилцуулахаар ажиллаж байна. **25.1.2.дүүргийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, түүнд тавих хяналт;** 2024 онд нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн 6 төсөл хөтөлбөр, арга хэмжээний 812,0 сая төгрөгийг 2 байгууллагын данс бүртгэлд бүртгэн дүүрэг болон ОНХС-гийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлсэн 18 төсөл, арга хэмжээний 1,7 тэрбум төгрөгийн ажлыг данс бүртгэлд тусгаад байна. **25.1.3.дүүргийн төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан, хяналт;** Дүүргийн Засаг даргын 2025 оны А/11 дүгээр захирамжаар 2025 оны дүүргийн төсвийн орлого, зарлагын сар, улирлын хуваарийг батлуулав. Дүүргийн 2025 оны төсөвт өөрчлөлт орсонтой холбогдуулан төсвийн хуваарьт Засаг даргын 2025 оны А/88 дугаар захирамжаар өөрчлөлт оруулсан. Дүүргийн 2025 оны батлагдсан төсвийг Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангиллаар хянан, төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулан ажиллалаа. 2025 оны 11 дүгээр сарын байдлаар төсвийн төлөвлөгөө 13,687,9 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 12,153,0 сая төгрөгийг зарцуулан, 1,534,0 сая төгрөгийн хэмнэлттэй ажиллав. **25.1.4.хууль тогтоомжид заасан хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох асуудал;** Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурал нь: - 2019 оны "Соёлын ордны төлбөрт үйлчилгээний хураамж, түрээсийн төлбөрийн хэмжээг тогтоох тухай" А/14 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар үйлчилгээний төрөл, үйлчилгээний үнийн хураамжийг; - 2021 оны Биеийн тамир, спортын хорооны үйлчилгээний төлбөр, хураамжийн тогтоох тухай" А/07 дугаар тогтоолоор Биеийн тамир, спортын хорооны заалыг		

					ашиглах цагийн төлбөрийн үнэ тарифыг; - 2021 оны "Малын хөлийн тоо толгойд ногдуулах албан татварын хэмжээг тогтоох тухай" А/01 дүгээр тогтоол; - 2022 оны Машин механизм түрээсээр ажиллуулах тухай А/22 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар "Багахангай тохижилт" ОНӨААТҮГ-ын машин механизм, тоног төхөөрөмжүүдийг түрээсээр ажиллуулах тарифыг, хоёрдугаар хавсралтаар "Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ-ын машин механизм, тоног төхөөрөмжүүдийг түрээсээр ажиллуулах тарифыг, - 2023 оны "Дүүргийн нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" А/15 дугаар тогтоолыг тус тус баталж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. **25.1.5.дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хуваарилалт болон бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлан, хяналт;** Нийслэл болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд иргэдээс цахим санал, асуулга авах ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хооронд зохион байгуулав. onhs.mof.gov.mn, "ОНХС" гар утасны аппликейшн болон "e-mongolia" аппликейшнаар санал авч санал асуулгад 2516 иргэн хамрагдахаас 1840 иргэн санал өгч 73.1 хувьтай дууслаа. ИНХ-аар 1, 2 дугаар хорооноос 17 төсөл арга хэмжээний саналыг ирүүлж, Засаг даргын удирдах зөвлөлд танилцуулаад байна. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,257.6 сая төгрөгийн он дамжсан 4, шинээр хэрэгжих 13, нийт 17 төсөл, хөтөлбөр арга хэмжээ төлөвлөгдсөнөөс 14 ажил 100 хувь, 3 ажил 80 хувь хэрэгжин нийт гүйцэтгэл 96.4 хувьтай байна. ОНХС-гийн хөрөнгөөр 500,1 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээ хэрэгжиж гүйцэтгэл 100 хувьтай байна. **25.1.6.худалдаа, үйлчилгээний зөвшөөрөл, хяналт;** Ахуйн үйлчилгээ, худалдаа, хоол үйлдвэрлэл, хүнсний үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд болон иргэдийн судалгааг гарган УБЗАА-нд хүргүүлэв. Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар Хяналтын хэлтсийн Хүнсний чанар, стандартын хяналтын Улсын ахлах байцаагч нартай хамтран Хяналт шалгалтын удирдамжийн дагуу Хүнсний худалдааны газруудын төлөвлөгөөт 2 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 32 байгууллагын эрсдэлийг үнэлж, дүгнэх, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, таслан зогсоох, хүнсний аюулгүй байдлын		

					болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөмж, албан шаардлага хүргүүлэх ажлыг зохион байгуулав. Дүүрэгт үйл ажиллагаа эрхэлж буй худалдаа үйлчилгээ, хоол үйлдвэрлэл эрхлэгчдэд ЗДТГ, НХХААГ, дүүргийн Насан туршийн суралцахуйн төв, Онцгой байдлын хэлтэстэй хамтран "Худалдаа үйлчилгээний байгууллагын соёлыг дээшлүүлэх нь" сэдэвт сургалтыг зохион байгуулж, нийт 36 төлөөллийг оролцуулав. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилт, нийслэлийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр согтууруулах ундаагаар үйлчилдэг, худалдан борлуулдаг 12 аж ахуйн нэгжид дүүргийн Цагдаагийн хэлтэс, Татварын хэлтэстэй хамтран тайлангийн хугацаанд давхардсан тоогоор 9 удаагийн үзлэг, шалгалтыг зохион байгуулж зөвлөмж, чиглэл өгч ажиллав. Тамхины зөвшөөрөл сунгасан талаар Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх хүсэлтийг www.e-business.mn, www.e-mongolia.mn-ээр хүсэлтийг хүлээн авч, холбогдох хууль тогтоомж, баримт бичгийн бүрдэл хангасан 2 аж ахуйн нэгжид тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгосон Улсын тэмдэгтийн хураамжаар 500,000 төгрөгийн татварын орлого бүрдүүлэн ажилласан. **25.1.7.нийслэлийн үйлдвэрлэлийн хөтөлбөрийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөрийн хэрэгжилт;** Монгол Улсын Их хурлын Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 36 дугаар тогтоолын дагуу 11 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. МУЗГ-ын 36 дугаар тогтоолын 2022-2025 оны хэрэгжилтийн тайланг гарган НХХААГ-т 2025 оны 08/340 дугаар албан бичгээр хүргүүлэв. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон "Дархан хотын Малын удмын сангийн үндэсний цогцолбор"-т малын чанар үүлдрийг хэрхэн сайжруулах талаар дүүргийн удирдлага, холбогдох мэргэлжилтэн нар мэргэжил арга зүйн зөвлөгөө авч ажилласан. Малын чанар үүлдрийг сайжруулах зорилгоор 12,7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийн ажил зохион байгуулж нийлүүлэгчээр "Энхсүү наф" ХХК нь шалгарч Монбелярд үүлдрийн мах-сүүний чиглэлийн 2 бухан бяруу худалдан авч 1 дүгээр хорооны малчин Ч.Бямбадаш, 2 дугаар хорооны малчин Э.Эрдэнэсүрэн нартай гэрээ байгуулан хүлээлгэн өгөв. Дүүрэгт "Мобс" хоршоо нь малын мах, сүү, түүхий эд авч борлуулах, "Хангайн мэргэн" хоршоо нь үржлийн мал худалдан бойжуулах, борлуулах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг. "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" хөдөлгөөн		

					хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан дүүргийн малчин болон мал бүхий өрхийн 25 иргэнд хоршооны талаарх мэдээллийг хүргэн ажилласан. "Хангайн мэргэн" хоршоо нь 13 гишүүнтэй үүнээс 5 гишүүн 218,5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан. Дүүргийн "Хөдөө аж ахуйн салбарын зөвлөгөөн"-ийг зохион байгуулсан бөгөөд зөвлөгөөнд Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны харьяа Малын удмын сангийн үндэсний төв,Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, дүүргийн ХХҮГ, НДГ, дүүргийн ЗДТГ, Цагдаа, Татвар, Хаан, Төрийн банкнызэрэг газрууд малчид болон газар тариалан эрхлэгч нарыг мэдээллээр хангалаа. Зөвлөгөөнд малчин, мал бүхий иргэд, газар тариалан эрхлэгч нарыг төлөөлж 138 хүн оролцож дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 2,3 сая төгрөг зарцуулав. **25.1.8.дүүргийн сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, номын сан, биеийн тамир, спортын цогцолборын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар;** Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны "Дүүргийн 2025 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" А/09 дүгээр тогтоолоор ЕБС, СӨББ-ууд, Эрүүл мэндийн төв, Биеийн тамир, спортын хороо, Соёлын ордон гэсэн 7 ААНБ-ын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт болон урсгал засварын зардалд нийт 2,213,676.7 тэрбум төгрөгийн төсвийг хуваарилан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Ерөнхий боловсролын 94 дүгээр сургуулийн спорт заалны шал болон дээврийн засвар, 91 дүгээр сургуулийн дотор засварыг 433,1 сая, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар боловсролын байгууллагуудад ухаалаг самбар нийлүүлэх ажлыг 112,0 сая төгрөгөөр гүйцэтгэв. **25.1.9.дүүрэг дэх авто зогсоолын арчилгаа;** Дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн 9 байршилд 278 авто зогсоол ашиглаж байгаа боловч нийт авто машин эзэмшигчдийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна. Иймд дүүргийн хэмжээнд 4 байршилд 160 авто машины зогсоолыг шинээр байгуулахаар төлөвлөснөөс 2025 онд 1, 2 дугаар хорооны Сургуулийн өмнөх боловсролын 207 дугаар цэцэрлэг, 44 дүгээр цэцэрлэгийн гадна дүүргийн төсвийн хөрөнгөөр авто зогсоолын ажил хийгдэхээр (106,3 сая өртөг бүхий 360м^2 талбайд 14 авто зогсоол) дүүргийн Засаг даргын 2025 оны А/08 дугаар захирамжаар үнэлгээний хороо байгуулагдаж 8 удаа тендер зарлагдаж гүйцэтгэгч шалгараагүй тул төсвийн тодотголоор санхүүжилт татагдсан. **25.1.10.нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламжийн арчилгаа,**		

					хамгаалалт; Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/237, дүүргийн Засаг даргын А/47 дугаар захирамжаар ажлын хүрээнд дүүргийн 1, 2 дугаар хороонд "Орчны аюулгүй байдлыг хангах, үзлэг шалгалтыг 4 удаа зохион байгуулав. Хүүхдийн нэгдсэн тоглоомын талбайн аюулгүй байдалд тогтмол хяналт тавьж ажиллахад 87 зөрчил илэрч арилган ажиллав. 2025 оны Нийслэлийн Засаг даргын А/560 дугаар захирамжийн дагуу хороодын тохижилтын ажлыг хэрэгжүүлэх хүрээнд дүүргийн 1 дүгээр хороонд тохижилтын 3 нь үе шаттай ажил арга хэмжээ хийгдсэн. Үүнд Үнэгтэй, Алтгана гэр хорооллын үерийн усны улмаас үүссэн 0.3–0.7м гүнтэй гуу, жалгыг тэгшлэх, Үнэгтэй гэр хорооллын хөлбөмбөгийн талбайн 1,188 м² талбайг хашаа 1 ширхэг сүүдрэвч, 1 Үнэгттэй гэр хороололд байрлах тоглоомын талбайн тоглоом,0-3 нас, 4-12 насны хүүхдүүд тоглох стандартын шаардлага хангасан тоглоомын талбайн гүйцэтгэхэд 50,0 сая төгрөгийн тохижилт хийгдсэн. Мөн дүүргийн 2 дугаар хороонд "Ахмадын төгөл" нийтийн амралтын зориулалттай газар бий болгох хүрээнд хөшөө, 3,6-ийн дм-тэй болон 3х3 2 ширхэг сүүрэвч, бялдаржуулах төхөөрөмж 6 ширхэг, гэрэлтүүлэг 8 ширхэг, 210м модон олстой хашаа, явган зам 50 метр урт, 1.5 метр өргөнтэй, нийт 60м² талбай бүхий явган зам зэрэг тохижилтийн ажлын гүйцэтгэл 80% явагдаж байна. **25.1.12.дүүргийн гэрэлтүүлэг, арчлалт;** Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн 930 ш гэрэлтүүлгийн засвар үйлчилгээг "Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж" ОНӨААТҮГ тухай бүр гүйцэтгэж, гэрэлтүүлгийн асалтыг 100%-д хүргэн ажиллалаа. Тайлангийн хугацаанд 1, 2 дугаар хорооны Үнэгтэй, Замчин, Бор-Үзүүр, Нуурын гэр хорооллын нийт 21 ширхэг гэрэлтүүлэг сольж, 1 дүгээр хорооны 2, 4 дүгээр байрны дээр байрлах "СОЁЛТОЙ-ИРГЭН", "ТОХИЛОГ-ОРЧИН" үсгэн гэрлийг шинээр байршуулсан байна. **25.1.13.дүүргийн төвлөрсөн бус хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт, байршил, ашиглалт, хамгаалалт;** Дүүрэгт Ус суваг ашиглалтын товчоо болон УБТЗ-ын Эрчим хүч, ус хангамжийн анги нь иргэн, аж ахуйн нэгжийн унд ахуйн шаардлагад нийцсэн усаар хангаж ажилладаг. Умард говийн гүвээт халхын дунд савын усны захиргаанаас дээрх 2 газарт дүгнэлт гаргуулахаар хандсан. Мөн НҮБ-ын Хүүхдийн санд тус 2 газрыг хашаажуулах асуудлын санхүүжүүлэх талаар хүсэлт гаргав. Тайлант хугацаанд шинээр худаг, цооног гаргах зөвшөөрөл хүссэн иргэн байхгүй. 1 аж ахуй нэгж ус ашиглах зөвшөөрөл хүссэний дагуу нийслэлийн Байгаль орчны газрын ус		

					ашиглах дүгнэлтийг үндэслэн дүүргийн Засаг даргатай ус ашиглах гэрээг байгуулж ажилласан. Мөн тайлангийн хугацаанд ААНБ 8ш, 13 айл өрхийн 28ш хүйтэн халуун усны тоолуурыг Ус суваг ашиглалтын товчоо нь баталгаажуулан ажилласан байна. **25.1.14.хог хаягдлын менежмент.** Багахангай тохижилт ОНӨААТҮГ-ын ахуйн хог хаягдлыг цуглуулж, зөөж тээвэрлэх, маршрут, график өвлийн хуваарьт гэр хорооллын хог тээврийг 7 хоногт 1 удаа, орон сууцны хог тээврийг өдөрт 2 удаа ачиж тээвэрлэдэг. Зуны хуваарьт шилжсэнээр 1 дүгээр хорооны орон сууцны хогийг өдөр бүр, гэр хорооллыг 14 хоногт 1 удаа, 2 дугаар хорооны орон сууцны хогийг 1, 3, 5 дахь өдөр ААНБ-тай цуг, гэр хорооллыг 1, 3 дахь өдөр тус тус ачиж тээвэрлэж байна. Хог тээвэрлэлтийн ажилд хороодын Тохижилт, хог хаягдлын олон нийтийн байцаагчаар дамжуулан тогтмол хяналт тавин ажиллаж байна. Тайлант хугацаанд 74 аж ахуйн нэгж, байгууллага, худалдаа үйлчилгээний байгууллагуудтай "Тохижилт, цэвэрлэгээ"-ний гэрээ байгуулан гэрээний хавсралтад байгууллага орчны 50м зураглал хорооны тохижилт, хог хаягдлын байцаагч нараар баталгаажуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Дүүргийн 1, 2 дугаар хорооны нийтийн эзэмшлийн орон сууцны айл өрхийн 7578тн, гэр хорооллын айл өрхийн 5423тн, дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа албан байгууллага, аж ахуй нэгж байгууллагын 1741тн, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, гуу жалганы алслагдсан байршлуудад хийгдсэн түүвэр цэвэрлэгээгээр 231тн хог хаягдлыг татан авч нийт 14943тн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэн, дарж булшлав. Хэрэгжилтийн хувь 100		

2	Арга хэмжээ 3.1.2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр шуурхай зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд байршуулан, Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар батлагдсан "Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам" (хүчингүй болсон)-тул үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах;	-	Хууль тогтоомжийн хэрэгжилт, хувь	90	Төрийн Худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д 2025 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хуулийн хугацаанд шивж баталгаажуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийт 26 ажлаас нээлттэй тендер шалгаруулалтын журмаар-8, шууд худалдан авалтаар-10, харьцуулалтын аргаар-8 ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулсан. Жилийн эцсийн байдлаар шууд гэрээнээс бусад 18 бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулж иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлэв. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн тайлан мэдээг хуулийн хугацаанд shilendans.gov.mn сайт болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулж ажиллав. Үүнд: - Дүүргийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн 2025 оны 01-11 дүгээр сарын мэдээ; - Төсвийн Ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт; - 2025 оны батлагдсан төсөв, дүүргийн 2025 оны төсөвт орсон өөрчлөлт; - Төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн мэдээ; - 2025 оны 01-11 дүгээр сарын зарлагын мэдээ; - Төсвийн зарлагын 2025 оны 1, 2 3 дугаар улирлын гүйцэтгэл; - ТЕЗ-ийн 2024 он, 2025 оны эхний хагас жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлан; - ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан; - 2025 оны Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө; - Шилэн дансны цэсэнд сар бүр 30 төрлийн мэдээг, улирал бүр 16, бүтэн жил 4, нийт 50 мэдээг хуулийн хугацаанд байршуулав. Хэрэгжилтийн хувь 100	100	100

3	Арга хэмжээ 3.1.3. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйл, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх бөгөөд холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор UBlegal.ulaanbaatar.mn цахим хуудаст байршуулж, олон нийтийг танилцах боломжоор хангах;	-	Хууль тогтоомжийн хэрэгжилт	90	Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан нээлттэй мэдээллийн ил тод байдлын shilen.gov.mn сайтын сургалтад холбогдох албан хаагчийг хамруулан, байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах 5 бүлэг, 87 шалгуур үзүүлэлт бүхий тайланг 2025 оны 2 дугаар улирлын байдлаар гарган Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газарт хүргүүлэв. ublegal.ulaanbaatar.mn сайтад А/232, Б/15 захирамжийг тус тус байршуулаад байна. Дүүргийн www.bagakhangai.ub.gov.mn сайтад нийт 901 мэдээ мэдээлэл, 158 нийслэл дүүргийн шторк, 232 захирамж байршуулж ажиллалаа. Сайтын өнгө загвар шинэчлэн 9 дэд цэс нэмэн мэдээллүүдийг тогтмол шинэчилж байна. Тайлангийн хугацаанд дүүрэгт зохион байгуулагдсан 82 томоохон ажил, арга хэмжээний мэдээллийг дүүргийн веб сайтад байршуулсан ба нийслэлийн хэмжээний мэдээллийг дүүрэг орон нутагтаа сурталчлах ажлын хүрээнд 156 мэдээллийг веб сайтад байршуулан иргэд олон нийтийг мэдээ мэдээллээр ханган ажиллалаа. 2025 оны 04-р сарын 01-ний өдрөөс Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын пэйж хуудсыг нээж, дүүргийн Засаг даргын Тамгын газраас хэрэгжүүлж буй бодлого шийдвэр зохион байгуулж байгаа цаг үеийн арга хэмжээний нийт 907 гаруй мэдээ бэлтгэж, 75 шторк бичлэг хийж, үйл явдлын мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэн ажиллалаа. Мөн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын цаг үеийн мэдээ мэдээлэл, "Улаанбаатар мэдээ" цахим хуудаст орсон мэдээллийг дүүргийн цахим хуудсаа байршуулан ажиллаж байна. Энэ оны 12 дугаар сарын байдлаар нийслэлийн 80 гаруй мэдээг байршуулж, олон нийтэд хүргэсэн байна. Түүнчлэн 7 хоногийн тойм, 5 хоногийн цаг агаарын мэдээг бэлтгэн хүргээд байна. Дүүргийн мэдээллийн цахим сувгуудад байршуулсан мэдээлэл давхардсан тоогоор 10,000 гаруй хандалт аваад байна. Хэрэгжилтийн хувь 100	100	100
4	Арга хэмжээ 3.1.4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт заасан үүргийг хэрэгжүүлэх;	-	Хууль тогтоомжийн хэрэгжилт	90	Дүүрэгт 2025 оны 11 сарын байдлаар 25 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8 нэгжээр буюу 47,1 хувиар өссөн. Дүүргийн Засаг дарга, ГХУСАЗСЗ-өөс Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу 17 ажил зохион байгуулсан. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд "Сар шинэ-2025","Замын хөдөлгөөний цагаан толгой","Ногоон гэрэл, цагаан шугам", "Байгалиа хамгаалъя", "Ухаарлын хором", "Анзаар-2, "Аюулгүйн хонх", "Орон нутгийн зам хөдөлгөөний соёл-2025" зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулан 38,193,650 төгрөгийг зарцуулсан. "Өнөөдөр сонго, маргаашийг хамтдаа бүтээе", "Иргэн таныг сонсъё", "Хүүхэд таныг хамгаалъя" зэрэг 3 удаагийн нээлттэй	90	90

					хаалганы өдөрлөгийг зохион байгуулсан. Замын хөдөлгөөний гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дронт эргүүл, хөдөлгөөнт эргүүл, мотоцикилт эргүүл, өрхийн хяналт, захиргааны хяналт, гудамж замын хяналт, теле камерын хяналт зэргийг тогтмол зохион байгуулсанаар гэмт хэрэг, зөрчлийн илрүүлэлт 100 хувьтай байна. Дронт эргүүлийг 920 удаа зохион байгуулж, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж гудамж, талбайд унтаж байсан 32 иргэнийг илрүүлэн ар гэр, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч, тогтоол усанд тоглож байсан 41 хүүхдийг живэх эрсдэлээс сэргийлж, баталгаат бус замаар хөдөлгөөнд оролцсон 52 жолоочийн зөрчлийг илрүүлэн шалгаж алба хаагчийн ачааллыг бууруулсан. Бүлэг, бөөгнөрөл үүсгэн архидан согтуурдаг, удаа дараа зөрчилд холбогдсон 25, орон гэргүй тэнэмэл 1 иргэний судалгааг шинэчлэн, айл өрхийг хяналтад авч давхардсан тоогоор 2520 айл өрхийн 3780 иргэнд зөвлөмж өгч, бүлэг бөөгнөрлийг саармагжуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлсэн. "Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай" хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 12 удаагийн хяналт, шалгалтыг зохион байгуулсан. Насанд хүрээгүй хүүхдэд согтууруулах ундааны зүйл худалдсан 4 ААНБ-д ЗТХ-ийн 6-р зүйл, 5.9 дэх хэсэгт зааснаар 10,000,000 төгрөгийн торгууль оногдуулсан. Хэрэгжилтийн хувь 90		
5	Арга хэмжээ 3.1.5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг ханган, тайлагнаж ажиллах;	90 17,3	Хууль тогтоомжийн хэрэгжилт, хувь	90	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хянах, сайжруулах чиг үүргийг хэрэгжүүлэх дүүргийн "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг Засаг даргын 2025 оны А/51 дүгээр захирамжаар 13 хүний бүрэлдэхүүнтэй шинэчилж, захирамжийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв. ХАБЭАхуйн салбар зөвлөл нь ХАБЭА-н сарын аяны нээлтийг "Хөдөлмөр эрхлэлт-2025" сэдвийн хүрээнд 04 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулав. Тус аяны хүрээнд "Вэст метод хөдөлмөрийн бирж, Эм Эс Девелопмент сургалтын төв"-тэй хамтран аж ахуйн нэгж, байгууллагын удирдах албан тушаалтнууд болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан, албан хаагчдад "Хөдөлмөрийн харилцаа, ХАБЭА-н хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал", "Эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгоход ажил олгогчийн үүрэг оролцоо" сэдвээр 4 цагийн сургалтыг зохион байгуулж, тус сургалтад төр, хувийн хэвшлийн 30 аж ахуйн нэгж, байгууллагын 123 ажилтан, албан хаагч, 45 иргэн, нийт 168 хүн хамрагдав.	100	100
			Зарцуулсан хөрөнгийн хэмжээ (сая төг)	14,3			

					Дэд бүтцийн байгууллагуудын багаж, тоног төхөөрөмжийн үзэсгэлэнг гарган УБТЗ-ын харъяа байгууллага дээр үзүүлэх сургуулийг зохион байгуулав. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн даргаар ахлуулсан ажлын хэсэг болон Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хөдөлмөрийн эрүүл ахуйн 4 байцаагчтай хамтран үйлдвэрлэлийн бүсэд үйл ажиллагаа явуулж буй "Синвоюань" ХХК, "Хангайн ган эрдэнэ" ХХК, "Ян Сарьдаг Оргил" ХХК-д 05 дугаар сард хяналт тавьж, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэв. Үзлэгийн үеэр илэрсэн зарим зөрчлийг газар дээр нь арилгуулж, хугацаатай шийдвэрлэх албан даалгавар өгөөд байна. Тайлант хугацаанд 30 аж ахуйн нэгж байгууллагын 123 ажилтан, албан хаагч болон 46 хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд сургалт зохион байгуулсан байна Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2025 онд хийж хэрэгжүүлэх ажил арга хэмжээний 3 зорилт, 25 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжилт 92 хувьтай байна. Тайлангийн хугацаанд давхардсан тоогоор 137 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг нийгмийн халамжийн 6 төрлийн үйлчилгээнд хамруулж 212,4, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 7 иргэнийг хамруулж 16,0 сая төгрөг тус тус зарцуулав. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх ОНОТХҮ-г үзүүлэх тендерт дүүргийн "Насан туршийн суралцахуйн төв", хөгжлийн бэрхшээлтэй байгын асаргаатай иргэн, хүүхдэд сэргээн засах үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах тендерт дүүргийн "Улаан загалмайн хороо" тус тус шалгарч 78 иргэнд үйлчилгээ үзүүлэв. Үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн тээврийн газартай хамтран "Багахангай-Улаанбаатар-Тэнгэр плаза" Х:18 чиглэлийн стандартын шаардлага хангасан 45 хүний суудалтай автобусыг 2025 оны 04 дүгээр сараас эхлэн өдөрт 3 удаа явуулж эхлэв. Зорилтот бүлгийн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөнгөлөлттэй үнээр зорчих боломжийг олгож ажиллав. "Марал-Элч сан"-тай хамтран "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эхчүүд, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн цахим ур чадварыг сайжруулах замаар эдийн засгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх нь" сэдэвт сургалтыг 04 дүгээр сард зохион байгуулж 18 иргэнийг хамруулав. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах 2025 оны төлөвлөгөөг 4 бүлэг 34 зааллтай боловсруулан хэрэгжилт 90%-тай байна.		

					Жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого, хууль тогтоомжийг аж ахуйн нэгж байгууллага, олон нийтэд таниулах, сурталчлах, хэвшмэл ойлголт хандлагыг өөрчлөх зорилгоор "Харилцан хүндэтгэе" аяны хүрээнд 6 сургалт, нөлөөллийн арга хэмжээнд 306 иргэн, 267 хүүхэд хамрагдсан бөгөөд цахимаар 5 төрлийн мэдээллийг түгээн 500 хандалт авав. "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр"-т хөндлөнгийн үнэлгээ хийлгэхээр дүүргийн 2025 оны төсөвт 3,0 сая төгрөгийг тусгуулсан ба хөндлөнгийн хяналт, шинжилгээ үнэлгээ хийлгэхээр "Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд" ТББ-тай гэрээ хийгээд байна. Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулж буй "Ментор менторшип" хөтөлбөрт хамрагдан дүүрэгт ажиллах ментор Б.Ононтой хамтран дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг хүйсээр ангилсан судалгааны ажил явуулав. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр танхим болон цахимаар зохион байгуулагдсан 8 төрлийн сургалтад 46 ажилтан албан хаагч хамрагдав. Жил бүр тэмдэглэн өнгөрүүлдэг жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян 2025 оны 11 дүгээр сарын 25-наас 12 дугаар сарын 10-ны хооронд "Технологи ашиглан үйлдэгдэж буй Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд нэгдье" уриан дор явагдаж байна. Аяны хүрээнд ЖҮХ-ны вэбсайтад байрлах удирдах ажилтны болон олон нийт иргэдэд зориулсан цахим тестийг бөглүүлэх иргэдийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна. Хэрэгжилтийн хувь 100		
6	Арга хэмжээ 3.1.6. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэгт заасан дүүргийн төсвийн шууд захирагч нарын бүрэн эрхийн хэрэгжилтэд хяналт тавих;	-	Хууль тогтоомжийн хэрэгжилт, хувь	90	Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтад хяналт шалгалт хийх, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирлагаар хангаж тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор нийцлийн аудит 15 байгууллагад төлөвлөгөөт 7 аудит, төлөвлөгөөт бус 2 хяналт шалгалт нийт 9 аудит хийсэн. Үүнээс 17 нийцлийн аудит, 6 гүйцэтгэлийн аудит, 2 санхүүгийн хяналт шалгалт хийж 15 зөрчил дутагдал илрүүлэн 15 зөвлөмж, тайлан мэдээг холбогдох газруудад хүргүүлж ажилласан. Хэрэгжсэн 100	90	90
7	Арга хэмжээ 3.1.7. Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.7 дахь хэсэгт заасны дагуу дүүргийн Засаг дарга нь олгосон газар	-	Хууль тогтоомжийн хэрэгжилт, хувь	100	Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны А/13 дугаар тогтоолоор дүүргийн 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг баталсан. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 120 дугаар тогтоолоор дэмжигдэж, Гэр бүлийн хэрэгцээний	100	100

	эзэмших, ашиглах эрх, тэдгээрийн нэгж, талбаруудын мэдээллийг газрын кадастрын мэдээллийн санд бүрэн бүртгэх;				зориулалтаар 136 иргэнд 9.5 га, төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд 2 байгууллагад 2.3 га, газар эзэмших эрхийн нээлттэй дуудлага худалдаагаар 8 ИААНБ-д 39.4 га, төсөл сонгон шалгаруулалтаар 1 Малчдын хоршоонд 5 га, өвөлжөө хаваржааны зориулалтаар 4 иргэнд 0.28 га газар эзэмшүүлж, ашиглуулсан. Хэрэгжилтийн хувь 100		
8	Арга хэмжээ 3.1.8. Хийн түлш, сэргээгдэх эрчим хүч хэрэглэгч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад хийн түлшний тоног төхөөрөмж болон аюулгүй ажиллагааны сургалт, мэдээлэл хүргэх, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах;	-	Аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан иргэн, ААНБ	-	Дүүргийн хэмжээнд шингэрүүлсэн хийн түлш, хийн тоног төхөөрөмжийн нэгдсэн цогц үйлчилгээ эрхлэх хүсэлт гаргасан аж ахуйн нэгж одоогоор байхгүй.	-	-
9	Арга хэмжээ 3.1.9. Агаарын бохирдолтой тэмцэх газрын үйл ажиллагааг дүүргийн Агаарын бохирдолтой тэмцэх тасаг, нэгжийн үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.	- -	Үйл ажиллагааны хэрэгжилт Бүрттэл тооллогод хамрагдсан өрх	90 297	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд агаарын бохирдлын эх үүсвэрийн бүртгэл, тооллогын ажлыг мэдээллийн сан дээр удирдамжийн дагуу 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 10-ны өдрийн хооронд дүүргийн 1, 2 дугаар хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд ердийн галлагаатай 3-15 кВт болон 16-100 кВт хүчин чадал бүхий зуухтай иргэн, аж ахуйн нэгж байгууллагын судалгааг маягтын дагуу, усан халаалтын 101-4200 кВт хүртэл хүчин чадалтай зуухны тооллого бүртгэлийг шинэ систем болох "Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогын мэдээллийн сан"-https://ubtoollogo.mn/-д тус тус бүртгэж ажиллав. Агаарын бохирдлын эх үүсвэрийн 2024 оны бүртгэл тооллогод нийт 297 өрх хамрагдав. Хэрэгжилтийн хувь 90	90	90
3.2.Төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд:							
10	Арга хэмжээ 3.2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцан ажиллах;	- -	Хууль тогтоомжийн хэрэгжилт, хувь Нийт байршуулах мэдээ Хуулийн хугацаанд байршуулсан мэдээ	100 32 29	Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, мэдээ тайлан, аудитын дүгнэлт зэрэг нийт 32 мэдээнээс 29 мэдээг хугацаанд нь байршуулж, 3 мэдээ хугацаа хоцорсон байна. Худалдан авах ажиллагааны албанаас Тендер шалгаруулалтад нийт 41 компани оролцсон. Үүнээс тендерт шалгарсан мэдэгдлийг 22, тендерт шалгараагүй мэдэгдлийг 19 компанид хүргүүлсэн бөгөөд шилэн дансанд оролцогч компаниудын мэдээллийг байршуулсан. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд https://shilendans.gov.mn/ сайтад 97 тушаал байршуулан ажиллав. Хэрэгжилтийн хувь 90	90	90

11	Арга хэмжээ 3.2.2. улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, зураг төсөв, бусад шаардлагатай бэлтгэл ажлыг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, 29.4 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д нийцүүлж төлөвлөх;	-	Хууль тогтоомжийн хэрэгжилт, хувь	100	Улс, нийслэл дүүргийн төсвийн хөрөнгөөр 2025 онд 29 төсөл хөтөлбөр арга хэмжээний 11,286.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж байна. Одоогийн байдлаар нийт гүйцэтгэл 97.1 хувьтай байна. Үүнд: 1. Улсын төсвийн хөрөнгөөр -4, 2. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр -5, Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,257.6 сая төгрөгийн он дамжсан 4, шинээр хэрэгжих 13, нийт 17 төсөл, хөтөлбөр арга хэмжээ төлөвлөгдсөнөөс 14 ажил 100 хувь, 3 ажил 80 хувь хэрэгжин нийт гүйцэтгэл 96.4 хувьтай байна. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны А/17 дугаар тогтоолоор 500,9 сая төгрөгийн 5 ажил батлагдан нийт ажлын гүйцэтгэл 100.0 хувьтай байна. Тендерийг зарлан гэрээ байгуулж дууссан 4 ажил он дамжин хэрэгжих 1 ажил байна. Мөн 2026 оны улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналд тусгуулахаар 5 төсөл, арга хэмжээг нэгтгэн дүүргийн ЗДТГ-ын 02/353 дугаар албан бичгээр НЗДТГ-т хүргүүлээд байна. Хэрэгжилтийн хувь 97,1	97,1	97,1
		10,887.0	Төсвийн хөрөнгөөр хэрэгжих нийт төсөл, арга хэмжээ	27			
		-	2026 оны улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналд хүргүүлсэн санал	5			
12	Арга хэмжээ 3.2.3. хөрөнгө оруулалтын ажлын гэрээний үүргийн хэрэгжилтэд хяналт тавихдаа гэрээний үүргийн хуваарь, ажлын тоо хэмжээний дагуу ажлын гүйцэтгэл, чанарт байнгын хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр арилгуулах арга хэмжээ авах, гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасан тохиолдолд уг аж ахуйн нэгж, байгууллагын талаарх мэдээллийг Төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнаж ажиллах;		Хөрөнгө оруулалтын ажлуудын гэрээний үүргийн хэрэгжилт	90	Орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсөвт тусгагдсан 1,757.8 сая төгрөгийн 22 төсөл хөтөлбөр, арга хэмжээнээс он дамжсан 6 ажил, шинээр хэрэгжих 16 ажлаас гэрээ байгуулагдан ажил дууссан 19, он дамжих 1, ажлын гүйцэтгэл 80 хувьтай-2 ажил нийт гүйцэтгэл 98.2 хувьтай байна. Улс, нийслэл, дүүрэг ОНХС-гийн талаар 2025 онд хэрэгжих төсөл хөтөлбөр арга хэмжээний төлөвлөгөөг 4, худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн тайланг 2, хөрөнгө оруулалтын явцын мэдээ 12, аудитын 2024 оны дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын дүгнэлт 3, нийт давхардсан тоогоор 35 мэдээ мэдээллийг шилэн дансны сайтад байршуулсан. Мөн гүйцэтгэгчээр шалгарсан тухай мэдэгдлийг 22 байгууллагад, шалгараагүй мэдэгдлийг 19 байгууллагуудад хүргүүлсэн. Мөн tender.gov.mn, shilendans.gov.mn сайтад тухай бүр тендер шалгаруулалтын үр дүнгийн талаар мэдээллийг байршуулсан. Хэрэгжилтийн хувь 100	100	100
13	Арга хэмжээ 3.2.4. Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг		Журмын хэрэгжилт, хувь	100	Дүүргийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдөр дүүргийн Засаг даргаар батлуулан 2025 оны 01 сарын 06-ны өдөр Төрийн Худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-сайтад хуулийн хугацаанд шивж баталгаажуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100	100
		-	Үйл	100			

	төлөвлөх, тайлагнах журам"-ын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-ээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 хоногт багтаан батлуулах, тайланг төсвийн жил дууссан даруйд системээр тайлагнана.		ажиллагааны хэрэгжилт		Эхний хагас жилийн байдлаар төлөвлөгөөг 3 удаа шинэчилэн батлуулж дүүрэг, ОНХС-гийн хөрөнгөөр он дамжсан 6, шинэ хөрөнгө оруулалтаар 14 ажлын нийт 1,7 тэрбум төгрөгийн 22 төсөл арга хэмжээ хэрэгжиж байна. Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийн талаарх мэдээллийг мэдээллийн самбартаа байршуулсан бөгөөд "tender.gov.mn" сайтад болон shilendans.gov.mn сайтад тендер шалгаруулалтын үр дүнг байршуулж нийтэд ил тод нээлттэй мэдээлж байна. Хэрэгжилтийн хувь 100		
3.3.Нийгмийн салбарын хүрээнд:							
14	Арга хэмжээ 3.3.1. улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт өөрийн харьяа нутаг дэвсгэрийн хүн амыг насны бүлгээр хамруулж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт ажил олгогчид болон салбар дундын хамтын ажиллагааг өрнүүлж хамрагдалтыг 70-аас доошгүй хувьд хүргэж ажиллах;	-	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамрагдалт, хувь	70	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 03 дугаар тогтоолоор дүүргийн Эрүүл мэндийн төв нь хүн амын тооноос шалтгаалан "Анхан шатны тусламж үйлчилгээ"-рүү шилжсэнтэй холбогдуулан эрт илрүүлэг үзлэгт 0-18 насны хүүхдийг хамруулах боломжтой байгаа ба насанд хүрэгчдэд үзлэг хийх эрх нээлгэх саналыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн боловч Эрүүл мэндийн яамнаас эрт илрүүлгийн үзлэгийн улсын хэмжээнд зогсоогоод байна. Тайлангийн хугацаанд дүүргийн ЭМТөвд нийт 37116 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 16679 буюу 44,9% хийгдсэн байна. Артерийн гипертензи эрт илрүүлэгийн үзлэгт 2822 хүн хамрагдахаас 817 хамрагдаж 28.9 хувь, Чихрийн шижин хэв шинж-2 үзлэгт 1728 хүн хамрагдахаас 787 хамрагдаж 45.5 хувь, Умайн хүзүүний эрт илрүүлгийн үзлэгт 276 хамрагдахаас 89 хамрагдаж 32.2 хувьтай тус тус байна. Хэрэгжилтийн хувь 44,9	64,1	64,1
		-	Артерийн гипертензи үзлэгт хамрагдалтын хувь	15			
		-	Чихрийн шижин хэв шинж-2 үзлэгт хамрагдалтын хувь	22,8			
		-	Умайн хүзүүний эрт илрүүлгэт хамрагдалтын хувь	22			
15	Арга хэмжээ 3.3.2. Засгийн газрын 2023 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл шүд" арга хэмжээг дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэх;		Арга хэмжээний хэрэгжилт, хувь	100	Дүүргийн иргэдэд амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй хүргэх зорилгоор НШЭНТ-тэй хамтран ажиллах гэрээг 2025 онд сунган ажиллаж байна. Эмальдент ХХК шүдний эмнэлэгтэй 2025 оны 01 дүгээр сарын 02-ноос хамтран ажиллах гэрээг сунган гэрээний хэрэгжилтийн хүрээнд 7 хоног бүрийн мягмар гаригт тогтмол үзлэгийг зохион байгуулдаг ба 2025 оны 11 дүгээр сарын 01-ний байдлаар нийт 238 хүн тусламж үйлчилгээ үзүүлснээс амны хөндийн өвчлөл 75%-ийг эзэлж байна.	90	90

		-	Амны хөндийн тусламж үйлчилгээнд хамрагдсан иргэд	166	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 44-р цэцэрлэгт 02 сард урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж 133 хүүхдийг хамруулав. Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан 2024 оны А/413, А/151 дүгээр тушаалын хэрэгжилтийг ханган Ерөнхий боловсролын сургуультай хамтран хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн сэдвээр 1 удаагийн сургалт зохион байгуулж 68 хүүхдийг хамруулсан. 44 дүгээр цэцэрлэгтэй хамтран багш ажилчдад зориулсан 1 удаагийн сургалтыг зохион байгуулж 26 ажилтан хамрагдсан. Нийслэлийн Шүд Эрүү Нүүрний төвийн эмч нар 2025 оны 10 дугаар сарын 17-ноос 10 дугаар сарын 21-ний хооронд дүүрэгт амны хөндийн эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулж 352 хүн үзснээс 1 жирэмсэн эмэгтэй, 3 ахмад настан, 348 хүүхдийг хамруулж эмчилгээ хийж, зөвлөгөө өгч ажиллав. Дүүргийн "Шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээн"-ийг 2025 оны 11 дүгээр сард зохион байгуулж 112 хүүхдийг хамруулж 2,5 сая төгрөг зарцуулав. Хэрэгжилтийн хувь 90		
		-	Амны хөндийн тусламж үйлчилгээнд хамрагдсан хүүхэд багачууд	207			
16	Арга хэмжээ 3.3.3. Засгийн газрын 2023 оны 321 дүгээр тогтоолоор батлсан "Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх" арга хэмжээг орон нутгийн түвшинд бусад салбар нэгжийн оролцоог ханган зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллах;		Арга хэмжээний хэрэгжилт, хувь	100	Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран амьдралын зөв дадал олгох, эрүүл мэндийн мэдээлэл өгөх 27 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт давхардсан тоогоор 328 иргэнийг хамруулав. Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааг тогтмолжуулах чанарыг сайжруулах зорилгоор 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс Нийгмийн эрүүл мэндийн эмчээр Г.Болдыг томилон ажиллуулж байна. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл хүргэх зорилгоор дүүрэг болон ЭМТ-ийн вэб сайт, цахим хуудаст 34 төрлийн 573 мэдээлэл, зөвлөмжийг байршуулж түгээсэн ба хандалт 9856 байна. Хэрэгжилтийн хувь 90	90	90
		-	Зохион байгуулсан сургалтын давтамж	23			
		-	Хамрагдсан ажилтан, албан хаагч, иргэд	340			
		-	Цахимд байршуулсан зөвлөмжийн давтамж	27			
17	Арга хэмжээ 3.3.4. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25.1.8. дахь заалтын дагуу	121,3	Хууль тогтоомжийн хэрэгжилт, хувь	100	Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "2025 оны төсөв батлах тухай" А/18 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн төвийн тогтмол зардалд 2025 оны төсөвт 121,3 сая төгрөгийг тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100	100

	дүүргийн эмнэлгийн барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар үйлчилгээний ажлын санхүүжилтийг дэмжиж, засвар үйлчилгээ, дулаан, цахилгаан, цэвэр усаар хангагдах нөхцөлийг бүрдүүлэн, тогтмол зардлыг хариуцан, төвийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж ажиллах;	134,9	Эмнэлгийн барилга байгууламж, засвар үйлчилгээ, тогтмол зардалд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ	68,3	Иргэдэд эрүүл ая тухтай орчинд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэх зорилгоор 2-р хорооны хэсгийн амбулаторийн байрыг засварлах, гадна пасад хийх, дээврийн төмөр солих засварын ажлыг дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 13,262,500 төгрөгөөр гүйцэтгэв. Мөн ЭМТ-ийн гадна хашаа будах, гадна орчны засварт 1,9 сая, өвөлжилтийн бэлтгэл хангах ажилд дулаалга, сангийн засварт 6,7 сая, түргэн тусламжийн автомашины гражийг засварын ажилд 6,7 сая төгрөгийг тус тус зарцуулав. Мөн Эрүүл мэндийн төвийн 40 ортой эмнэлгийн барилгын В1 давхрын ус зайлуулах хоолой хийх санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр саналыг дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хуралд хүргүүлээд байна. Хэрэгжилтийн хувь 100		
18	Арга хэмжээ 3.3.5. эрүүл мэндийн байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй иргэнд эмчилгээний тусламж, үйлчилгээ авах дэд бүтцийг бүрдүүлэн, эмчилгээний тусламж, үйлчилгээ болон тусламж, үйлчилгээтэй холбоотой мэдээлэл авах эрхийг бүрдүүлж ажиллах;	- -	ХБИ-ийн эмчилгээний тусламж, үйлчилгээ авах дэд бүтцийг бүрдүүлсэн байдал, хувь Эрүүл мэндийн үйлчилгээ авсан ХБИ	100 423	Тайлангийн хугацаанд давхардсан тоогоор амбулаториор 269, хэвтэн эмчлүүлэх тасгаар 93 хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хүүхэд эмчлүүлэв. 2025 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар давхардсан тоогоор 562 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж, 89 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулаад байна. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх мэдээллийг цахим болон шаардлагатай тохиолдолд утсаар холбогдон хүргэх, нийтэд зарлах ажлыг дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтран гүйцэтгэж байна. Эрүүл мэндийн төвөөс 1 ажилтныг дохионы хэлний сургалтад хамруулав. Хэрэгжилтийн хувь 90	90	90
19	Арга хэмжээ 3.3.6. дүүргийн Дотоод аудитын алба нь дүүргийн Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэх;	-	-	-	Дүүрэгт Өрхийн эрүүл мэндийн төв байхгүй болно.	-	-
20	Арга хэмжээ 3.3.7. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагаа, тусламж үйлчилгээний үр дүн, гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг харьяа хороодын хүн амын эрүүл мэндийн байдлын статистик үзүүлэлтийн тайланг хэлэлцүүлэн,	-	-	-	Дүүрэгт Өрхийн эрүүл мэндийн төв байхгүй болно.	-	-

	хэрэгжилтийг хангуулж ажиллах;						
21	Арга хэмжээ 3.3.8. хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ)-т өвчнийг тандах, илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт зориптот бүлгийг хамруулах арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, ажил олгогчидтой хамтран зохион байгуулж, халдвартай иргэдийг эмчилгээнд бүрэн хамруулж, эмчилгээний үр дүнг тооцож ажиллах;	-	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан иргэд	456	БЗДХ-т өвчнийг эрт илрүүлэх зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэгт 816 иргэнийг 2025 оны 11 дүгээр сарын 01-ний байдлаар хамруулан ажилласан. Шинжилгээнд өөрчлөлт гарсан 6 иргэнийг онош батлуулахаар ХӨСҮТ-д явуулахад хариу сөрөг гарсан байна. Дүүргийн Эрүүл мэндийн төв "Өсвөр үеэ сонсъё" аяныг зохион байгуулж тус аяны хүрээнд эх баригч бага эмч ерөнхий боловсролын 91, 94-р сургуулийн 126 сурагчдад бэлгийн эрүүл ахуй талаар сургалт, гарын авлага 150 ширхэгийг боловсруулан хүргэв. Түүнчлэн Монголын Сүрьеэгийн нийгэмлэгтэй хамтран сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж, нийт 114 иргэнийг хамруулснаас 21 иргэнээс сорьц авч ХӨСҮТ-д онош тодруулах шинжилгээнд хамруулллаа. Хэрэгжилтийн хувь 90	90	90
		-	Сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдагсад	114			
22	Арга хэмжээ 3.3.9. жирэмсний эрт үеийн хяналтын хамралтыг нэмэгдүүлэн жирэмсэн үеийн гуравласан халдвар (ХДХВ, тэмбүү, гепатитын В, С, вирус)-ын илрүүлэг шинжилгээний хамрагдалт, тэмбүүтэй жирэмсэн эмэгтэйн эмчилгээ, эмчилгээний дараах хяналт, бэлгийн хавьтагчийн илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний байдалд байнга хяналт тавьж төрөлхийн тэмбүүгийн тохиолдол гаргахгүй ажиллах;	-	Жирэмсний хяналтад орсон эх	28	Тайлангийн хугацаанд жирэмсний хяналтад нийт 53 жирэмсэн эмэгтэй орсон ба эхний 3 сартай хяналт 44 буюу 83 хувьтай байна. Хяналтад авсан жирэмсэн эмэгтэйчүүдээс В, С вирус болон ХДХВ тэмбүүгийн өвчлөл илрээгүй байна. Жирэмсний хяналт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор эмэгтэйчүүдийн их эмч, эх баригч бага эмч нийт 2 орон тоотойгоор тусламж үйлчилгээг үзүүлж байна. 2025 онд төрөлхийн тэмбүү бүртгэгдээгүй. Хэрэгжилтийн хувь 83	92,2	92,2
		-	Хяналтад орсон нийт эхээс эхний 3 сартай хяналтад орсон эхийн эзлэх хувь	90			
23	Арга хэмжээ 3.3.10. эх, нялхас, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, ялангуяа сэргийлж болох эндэгдлийг тууштай бууруулах чиглэлээр тэгш, хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээг зохион байгуулж, эх, хүүхдийн эндэгдэлд судалгаа хийж, хариу арга хэмжээ хэрэгжүүлэн үр дүнг тооцон ажиллах;	-	Урьдчилан сэргийлэх сургалтад хамрагдагсад	25	Тайлангийн хугацаанд эх нялхас, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл бүртгэгдээгүй байна. Үүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор жирэмсний хяналтын үзлэгийг сайжруулан жирэмсэн эхчүүдэд 4 удаа сургалт явуулж, давхардсан тоогоор 56 жирэмсэн эмэгтэй хамрагдсан байна. Мөн төрөх насны 15-45 насны эмэгтэйчүүдийн судалгааг нарийвчлан гаргаж урьдчилан сэргийлэх үзлэгт 152 эмэгтэйг хамруулав. Зорилтот бүлгийн 138 эмэгтэйчүүдээс 87 эмэгтэйг жирэмснээс хамгаалах эм, тариа, суулгацад хамруулснаар эрсдэлт бүлгийн иргэдийн 63 хувийг жирэмснээс сэргийлэх аргад суралцуулан урьдчилан сэргийлэн ажилласан байна. Дүүргийн ерөнхий боловсролын 91,94-р сургуулийн өсвөр насны 167 сурагчдад Эрүүл мэндийн төвийн бага эмч "Бэлгийн ариун цэвэрт хэрхэн суралцах" талаар сургалт зохион байгуулав. Хэрэгжилтийн хувь 100	100	100
		-	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан эх	129			

24	Арга хэмжээ 3.3.11. эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.	-	Нийгмийн баталгаа нь хангагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн	7	Эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтний сул орон тоог нөхөх, нийгмийн баталгааг хангаж, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, орон нутгийн нэмэгдэл, хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд илүү цаг, баяр, шөнийн цагийн нэмэгдлийг сар бүр, ажлын гүйцэтгэлийн үр дүнгийн урамшууллыг 60 хүртэлх хувиар тус тус тооцон тогтмол олгож байна. Мөн дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2024 оны А/18 дугаар тогтоолын дагуу Эрүүл мэндийн төвд үндсэн эмчээр ажиллах 6 хүртэлх эмчид орон нутгийн нэмэгдлийг 40 хувиар нэмэлтээр олгохоор гэрээг ЗДТГ, ЭМТ-тэй байгуулан ажиллаж байна. Уг гэрээний дагуу шалгуур хангасан 6 эмчид үндсэн цалингийн 40 хувийн орон нутгийн нэмэгдэл олгож, 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 32,032,360 төгрөгийг дүүргийн төсвөөс зарцуулаад байна. Мөн дүүргийн төрийн албан хаагчдын орон сууцны байранд 2 их эмч, 1 сувилагч амьдарч байна. Хэрэгжилтийн хувь 100	100	100
		12,6	Олгогдсон санхүүжилтийн хэмжээ (сая төг)	12,6			
25	Арга хэмжээ 3.3.12. хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, холбогдох стандартыг хангах ажлыг зохион байгуулах;	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Дүүргийн Засаг даргын 2021 оны А/11 дүгээр захирамжаар байгуулагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл 17 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Тус салбар зөвлөл 2025 онд 2 удаагийн хурлыг зохион байгуулж 7 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. Салбар зөвлөлийн 2025 онд хийж хэрэгжүүлэх ажил арга хэмжээний 3 зорилт, 25 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган биелэлт 98 хувьтай байна. Нийслэлийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлөөс 2025 оны 11 дүгээр сард дүүргийн салбар зөвлөлийн үйл ажиллагаатай танилцаж арга зүйн зөвлөгөө өгөв. Тайлангийн хугацаанд нийгмийн халамжийн хөнгөлөлт, тусламжид давхардсан тоогоор 137 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг нийгмийн халамжийн 6 төрлийн үйлчилгээнд хамруулж 212,4, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 7 иргэнийг хамруулж 16,0 сая төгрөг тус тус зарцуулав. Хөгжлийн бэрхшээлтэй хүний дэд бүтцийн хүртээмжийг дээшлүүлэх арга зүйн удирдамж"-ийн дагуу "UCS 1001 А" стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/237, дүүргийн Засаг даргын 2025 оны А/47 дугаар захирамжийн дагуу орчны аюулгүй байдлын үзлэг шалгалтыг 3 удаа зохион байгуулж илэрсэн зөрчлийг арилгах чиглэлээр холбогдох заавар зөвлөмжийг өгч зөрчлийг арилгах арга хэмжээг авч ажиллав. Мөн стандартыг таниулах, сурталчлах сургалтыг 1 удаа зохион байгуулж 22 байгууллагын	100	100
		4,3	ХБИ-ий хөнгөлөлт, тусламжид хамрагдагсад	12			
		-	ХБИ-ийн хүртээмжтэй байдлыг хангах хүрээнд засварласан явган замын хэмжээ	400м^2			

					ажилтан албан хаагч хамрагдав. "UCS 1001 C"–Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд дэд бүтцийн хүртээмжийг хангах стандарт"-ын хэрэгжилтийг хангах зорилгоор улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй 6 барилгад хяналт тавин ажиллаж байна. Дүүргийн 1 дүгээр хороонд НҮБ-ын Хүүхдийг ивээх сангийн хөрөнгө оруулалтаар "Нийтийн ариун цэврийн байгууламж"-ийг ашиглалтад оруулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөнгөлөлтэй үнээр үйлчлэх боломжийг бүрдүүлээд байна. Энэ онд дүүргийн хэмжээнд 1, 2 дугаар хорооны нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байрлах 400м2 явган хүний замын эвдрэл, гэмтлийг засварлав. Үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн тээврийн газартай хамтран "Багахангай-Улаанбаатар-Тэнгэр плаза" Х:18 чиглэлийн стандартын шаардлага хангасан 45 хүний суудалтай автобусыг 2025 оны 04 дүгээр сараас эхлэн өдөрт 3 удаа явуулж эхлэв. Зорилтот бүлгийн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөнгөлөлттэй үнээр зорчих боломжийг олгохоор ажиллаж байна. Хэрэгжилтийн хувь 100		
26	Арга хэмжээ 3.3.13. Монгол хэлний тухай хууль, холбогдох стандартыг дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын хэмжээнд мөрдүүлэх, холбогдох хяналт, хэрэгжилтийг хангаж ажиллах, төрийн албан хаагчдад үндэсний бичгийн сургалтыг Хэлний бодлогын үндэсний зөвлөл болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах;	-	Хууль тогтоомжийн хэрэгжилт, хувь	100	Монгол хэлний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан" Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III", Төрийн албан хэргийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хос бичгээр хөтлөх болсонтой холбогдуулан дүүрэгт багшлах нөөц бололцоог судалж харьяа байгууллагуудад сургуулийн 3 багш, ахмад 1 багш, байгууллагууд дотооддоо уйгаржин Монгол бичиг мэддэг албан хаагчдаар монгол бичиг сурах ажлыг зохион байгуулсан. Мөн байгууллагуудын даргын үйцэтгэлийн төлөвлөгөөнд төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж ажиллах тухай заалт тусган ажилласан. Дүүргийн архивын хэлтсээс харьяа байгууллагуудын хэвлэмэл хуудсын төслийг монгол бичгээр үйлдэж улсын байцаагчаар хянуулан Нийслэлийн архивын газарт 1215 хэвлэмэл хуудасны захиалгыг хүргүүлээд байна. Монгол бичгээр төрийн албан хэргийг хөтлөх ажлыг 2025 оны 01 дүгээр сараас эхлэн ИТХ, ЗДТГ, 2025 оны 03 дугаар сараас эхлэн дүүргийн харьяа 26 байгууллага хэвлэмэл хуудсанд буулган ажиллаж байна. Өрөө тасалгааны хаягийг монгол бичгээр бүрэн үйлдэж дууссан. Хэрэгжилтийн хувь 90	90	90
		-	Сургалтад хамрагдсан ажилтан, албан хаагчид	145			
		-	Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөж буй ААНБ	23			
		-	Архивын урьдчилсан үзлэгт хамрагдсан байгууллага	22			
27	Арга хэмжээ 3.3.14. сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын	-	Арга хэмжээний	100	Байгууллага болон багшийн ажлыг гүйцэтгэл үр дүнгээр үнэлэх ажлын хүрээнд 2024-2025 оны СӨББ-ын багшийн гүйцэтгэлийн	100	100

	сургалтын чанар, байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг ахиулахад чиглэсэн олон талт арга хэмжээг зохион байгуулах;		хэрэгжилт, хувь		үнэлгээ 04 дүгээр сарын 28-наас 05 дугаар сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулагдаж төрийн өмчийн 2 цэцэрлэгийн 8 багш, 8 бүлгийн 136 хүүхэд хамрагдсанаас 8 багш 1-3-р түвшинд үнэлэгдсэн бол 1 СӨББ 1-р түвшинд үнэлэгдэн урамшуулал авч байна. ЕБС-н гүйцэтгэлийн үнэлгээ 05 дугаар сарын 12-23-ны өдрүүдэд зохион байгуулагдаж төрийн өмчийн 2 сургуулийн 34 багш, 34 бүлгийн 806 сурагч хамрагдсанаас 1-р түвшинд 13 багш үнэлэгдсэн бол байгууллагын үнэлгээгээр 2 ЕБС 5-р түвшинд үнэлэгдэв. Боловсролын байгууллагууд сургалтын чанар, байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг ахиулах төлөвлөгөө гарган ажиллаж байгаагаас гадна Боловсролын хэлтэс, 207-р цэцэрлэг хамтран зүүн бүсийн 3 дүүргийн СӨББ-ын "Багшийн мэргэжлийн хөгжлийн бүлэг-"ийн гишүүдэд "Тоглоом, зохиол сонирхон судлах арга зүй" үзүүлэх сургалтыг зохион байгуулав. Уг сургалтад 23 багш хамрагдав. ЗДТГ-аас боловсролын байгууллагуудын гүйцэтгэлийн үнэлгээг ахиулах зорилгоор уулзалт ярилцлагыг 11 дүгээр сард зохион байгуулж байгууллага тус бүрээр дүгнэлт гаргуулан цаашид хэрэгжүүлэх саналыг нэгтгэн ажиллав. Хэрэгжилтийн хувь100		
28	Арга хэмжээ 3.3.15. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бэрхшээлийн хэлбэр, нөхцөл байдлаас үл шалтгаалан хамран сургах тойргийн цэцэрлэг, сургуульд хамруулж, танхимын болон хувилбарт сургалтаар боловсролын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр "Боловсролд хамрагдалтын дэмжих зөвлөл"-ийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах;	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Дүүргийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй нийт 28 хүүхдийн 19 нь сургууль, 9 нь цэцэрлэгийн насны хүүхэд бүртгэлтэй байна. 2025-2026 оны хичээлийн жилд 91, 94 дүгээр сургууль, НТССТ-д ялгаатай хэрэгцээт боловсрол шаардлагатай нийт 12 сурагч, 44 дүгээр цэцэрлэгт 2, 207-р цэцэрлэгт 3 хүүхэд ганцаарчилсан сургалтын хөтөлбөрөөр хичээллэж байна. Тэгш хамран сургах боловсролын чиглэлээр багш нарын сурагчидтай ажиллах арга зүйн чадварыг дээшлүүлэх зорилгоор "АДИНА" төслийн модуль сургалтанд 10 багшийг хамруулан арга зүйн дэмжлэгийг авч ажиллаж байна. 2025-2026 оны хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байгаа СӨББ-ын багш, багшийн туслах, ЕБС-ийн нийт 11 багшид БСШУС-ын сайдын 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/296 дугаар "Заавар батлах тухай" тушаалыг үндэслэн цалингийн 10%-иар нэмэгдэл хөлс олгож хэвшээд байна. Дүүргийн Засаг даргын 2022 оны А/37 дугаар захирамжаар байгуулагдсан "Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл"-ийн хурлыг тайлангийн хугацаанд 1 удаа зохион байгуулж боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа 5 настай 2 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх асран хамгаалагчтай	90	90
		-	ЕБС, СӨББ-д хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд	13			
		1,6	НТСТ-д суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд	2			

					уулзалт ярилцлага хийж, 207 дугаар цэцэрлэгт 200 багц цагийн хичээлд хамруулахаар шийдвэрлэж ажиллав. Тусгай хэрэгцээт хүүхдийн сурч хөгжих, бие даан амьдрах чадвар олгоход хүртээмжтэй, таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын 2025 оны А/73 дугаар захирамжаар 1,6 сая төгрөгийн өртгөөр Насан туршийн суралцахуйн төвийн тусгай хэрэгцээт сурагчдад боловсрол олгох танхимыг тохижуулж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангав. Хэрэгжилтийн хувь 90		
29	Арга хэмжээ 3.3.16. Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгаалллын сайдын 2023 оны А/23, А/80, А/189 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ (2023-2026)", "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангаж ажиллах;	-	Төлөвөлгөөний хэрэгжилт, хувь	100	БШУС, Эрүүл мэндийн сайд, ХНХС-ын 2023 оны А/23, А/80, А/189 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ (2023-2026)", "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 92 хувьтай байна. Тус төлөвлөгөөний хүрээнд KOICA олон улсын байгууллагатай хамтран 4-12 дугаар ангийн 340 сурагчдыг чихний сонсгол, чих хамар хоолойн үзлэгт хамруулж тэдний эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөгөө мэдээлэл өгөв. СӨББ-уудын бүлгийн багш, эмч, ажилтнуудад зориулан "Хүүхдийн хөгжлийн үнэлгээ, дэмжлэгийн арга зүй" сэдэвт сургалт зохион байгуулж, хүүхдийн хөгжлийн үнэлгээ, бүртгэл 2-5 насны хүүхдүүдэд зориулсан хөгжлийн цогц үнэлгээ (сэтгэлзүй, хөдөлгөөн, хэл яриа, нийгмийн харилцаа) хийж 276 хүүхдийг хамруууллаа. Хөгжлийн хоцрогдол илэрсэн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 9 хүүхдийг эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу витаминжуулалтад хамруулах, хооллолтод анхаарах, сүү уулгах, дасгал хөдөлгөөн, цэгэн иллэг, хүүхдийн иог зэрэгт хамруулснаар 3 хүүхдийн хоцрогдол хэвийн болоод байна. "Бага насны хүүхдүүдийг эхийн сүүгээр хооллохын ач тус" сэдэвт мэдээлэл өгөх уулзалтыг зохион байгуулж 21 иргэн хамрагдав. ЭМТ-өөс эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахаар ирсэн 271 хүүхдэд эрүүл аюулгүй хүнс, өсөлтийн зөвлөгөөг өгөв. Дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгаалллын хэлтэс нь төлөвлөгөөний хүрээнд нийт 3 сургагч багшийг бэлтгэсэн ба тайлант хугацааны байдлаар сургагч багш, сэтгэл зүйчтэй хамтран 3 байгууллагын 56 ажилтан албан хаагчдад "Бага насны хүүхдийн сэтгэл зүй, хөгжлийн хоцрогдол" сургалтыг зохион байгуулсан байна. Хэрэгжилтийн хувь 100	100	90
		-	Арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө-ний хэрэгжилт	90			
		-	Хөгжлийн хоцрогдол илэрсэн СӨББ-ын хүүхэд	9			
		-	Бага насны хүүхдийн сэтгэл зүй, хөгжлийн хоцрогдлын сургалтад хамрагдагсад	56			
30	Арга хэмжээ 3.3.17. ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад нийгмийн харилцаа, сэтгэл хөдлөл, ёс зүйд суралцах, 21	-	Арга хэмжээний хэрэгжилт, хувь	100	"Түншлэл-Үйлчилгээний соёлыг дээшлүүлэх" зорилтот жилийн хүрээнд ЕБС, СӨББ-уудад "Мэндэлье хүндэлье талархъя" аяныг зохион байгуулав. Аяны хүрээнд СӨББ-ын 10 бүлгийн 276 суралцагч болон нийт багш, ажилчид хамрагдан хүүхдүүдтэй	100	100

	дүгээр зууны иргэнд шаардагдах хувь хүний ур чадвар олгох хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх;	-	Хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдсан сурагчид	276	мэндлэх мэндчилгээний зураг самбарын дагуу өглөө, орой хүүхдүүдтэй мэндлэх соёлд суралцуулж "Өдөр тутмын мэндчилгээ", "Хүндэтгэлийн мэндчилгээ", "Баяр ёслолын мэндчилгээ", "Улирлын мэндчилгээ"-г хэрэглэж хэвшээд байна. Дүүргийн ЕБСургууиуд 1-12 дугаар ангийн 869 сурагчдад сургалт, яриа таниулга, бүтээлч үйл ажиллагаа, Гар зургийн уралдаан, Талархлын захидал бичих аян, Подкаст зэрэг нөлөөллийн ажил зохион байгуулав. Мөн 91 дүгээр сургууль нь багш, эцэг эх, ажилчдын төлөөлөл оролцож, хүүхдүүдтэй хамтдаа талархал илэрхийлэх, мэндчилэх, харилцан хүндлэх дадлыг биечлэн үлгэрлэн үзүүлсэн нь эерэг уур амьсгалыг бүрдүүлсэн байна. 94 дүгээр сургуулийн "ХӨУБ"-ын Ангийн дарга нарын холбооноос санаачлан сургалт хүмүүжлийн 5 өдрөө нэрэмжит өдөр болгон зарласан. - Даваа гариг -Мэндчилгээний өдөр; - Мягмар гариг -Талархлын өдөр; - Лхагва гариг -Бахархлын өдөр; - Пүрэв гариг -Хүндэтгэлийн өдөр; - Баасан гариг-Уучлалын өдөр болгон уриалга гаргав. Ерөнхий боловсролын 91 дүгээр сургууль сэтгэл зүйн сургалтыг 9 бүлгийн 224 сурагчдад 4 удаа, 10 бүлгийн 771 сурагчдад сэтгэл зүйн нөлөөллийн ажил зохион байгуулсан бол 94-р сургууль 7 бүлгийн 170 сурагчдад 7 удаагийн сургалт зохион байгуулав. Хэрэгжилтийн хувь 100		
31	Арга хэмжээ 3.3.18. ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн өөрийн удирдлагын байгууллага, хүүхэд бүрийн хөгжил, хамтын оролцоог дэмжсэн клуб, дугуйлангийн үйл ажиллагааг дэмжих, энэ чиглэлээр суралцагч, багш нарын ур чадварыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;	-	ХӨУБ-ын гишүүд	225	Дүүргийн хэмжээнд Хүүхдийн өөрөө удирдах байгууллагын 11 байгууллагад 225 сурагч хамрагдаж байгаа ба тайлант хугацаанд 12 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж давхардсан тоогоор 4150 сурагчдийг нөлөөллийн арга хэмжээнд хамрууллаа. Хүүхдийн 11 өөрөө удирдлагын байгууллагууд хамтын оролцоог хангаж "Их Нүүдэл" шатрын тэмцээний анхан шатны шалгаруулалтыг дүүрэгт зохион байгуулж 34 сурагчаас шалгарсан 24 сурагч Нийслэлийн шатны тэмцээнд амжилттай оролцсон байна. "Улаанбаатар лиг" волейболын тэмцээнд 91 дүгээр сургуулийн 14 сурагч оролцож 1,8 сая төгрөг, "Багахангай марафон-2025" өсвөрийн УАШТ-нд дүүргээс 4 насны ангилалд 85 сурагч, Дөл тэмцээний анхан шатыг дүүрэгт зохион байгуулж 2 баг оролцсоноос 91 дүгээр сургуулийн баг Нийслэлийн шатны тэмцээнд тус тус амжилттай оролцоод байна. Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Боловсролын хэлтэс хамтран хүүхдийн оролцоо, багаар ажиллах, хамтын ажиллагааг дэмжих зорилгоор зохион байгуулсан "No Smoke" нөлөөллийн арга хэмжээнд 13 ангийн 358 сурагч, 31 эцэг эх, асран хамгаалагч, иргэн, 11 ААНБ-ууд оролцон олон нийтийн сүлжээн	90	100
		-	Идэвхтэй хичээллэж буй дугуйлангийн төрөл	16			
		-	Дугуйланд хамрагдаж буй нийт сурагчид	334			

		-	Дугуйлан, клубын үйл ажиллагааг дэмжсэн дэмжлэгийн хэмжээ	4,3	дэх цахим хаягаар 14 видео контент, "Тамхинаас татгалцъя" сэдэвт 95 гар зургаар постер танилцуулга бэлтгэн олон нийтэд сурталчилж давхардсан тоогоор 62,403 хандалт авсан байна Нийслэлийн ерөнхий боловсролын 91 дүгээр сургууль нь 9 төрлийн дугуйлан хичээллүүлж 210, 94 дүгээр сургууль нь 7 төрлийн дугуйлан хичээллүүлж 124 сурагч нийт давхардсан тоогоор 16 төрлийн дугуйланд 334 хүүхэд хамрагдаж байна. Дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс нь "Хүүхдийн өөрөө удирдах байгууллагын манлайлал" төслийн уралдааныг зарлан хүүхэд бие биенээсээ суралцах, үнэн зөв мэдээллийг биендээ дамжуулах, хамтдаа хөгжих боломжийг бий болгон 5 төслийг шалгаруулж 2,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Хэрэгжилтийн хувь 90		
32	Арга хэмжээ 3.3.19. ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчин дахь хүүхэд хамгааллын асуудалд онцгойлон анхаарч, сургууль, дотуур байрны орчинд хүүхдийг аливаа хэлбэрийн дарамт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр нөлөөллийн ажлыг олон талт хэлбэрээр зохион байгуулах, зөвлөгөө мэдээлэл авах нээлттэй утас байршуулах;	-	Хүүхэд хамгааллын үйл ажиллагааны хэрэгжилт	100	Хороодын хамтарсан баг ЕБС-ийн хүүхдүүдэд үе тэнгийн дээрэлхэлт болон хүүхэд хамгааллын талаар 3 удаагийн арга хэмжээг 6 ангийн 162 сурагчдад зохион байгуулав. Ерөнхий боловсролын 91 дүгээр сургуулийн хүүхэд хамгааллын багаас 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн "Итгэлтэй утас"-ыг ажиллуулж эхлээд байна. Тайлангийн хугацаанд тус утаснаас сурагчид өөрийн гэр бүл, эцэг эх, асран хамгаалагч руу 300-350 дуудлага хийсэн байна. Өсвөр үе, залуучуудаас архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээний түвшинг үнэлэх WHO ASSIST асуулгын маягтад тулгуурласан сорилыг авч 92 сурагчийг хамруулав. Сорилын үр дүнгээс их эрсдэлтэй (хэрэглээний түвшин өндөр) 15 сурагчтай зөвлөгөөний тусгай баг байгуулж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Дүүргийн Цагдаагийн хэлтэс, ЕБС-иуд хамтран "Архи, тамхи, мансууруулах бодисын хор уршиг" сэдвээр сургалт зохион байгуулж 9, 10 дугаар ангийн 75 сурагчийг хамруулан "Чи хэн нэгний хувьд хамгийн тод гэрэл нь учир хорт зуршлаас татгалзаарай" аяны хүрээнд "Эрүүл амьдрал"-ын буланг сургуулиудад байршуулав. Мөн Инфографик, Шонхор бүлгэм, Мэдээллийн дуу хоолой, Өсвөрийн Улаанзагалмай ХӨУБ-туудтай хамтран урьдчилан сэргийлэх чиглэлээр 9-12 дугаар ангийн 120 сурагчдад 2 удаагийн сургалт нөлөөллийн ажлыг зохион байгууллаа. Дүүргийн Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран Үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтын эсрэг "Дээрэлхэгч биш Дэмжигч байя" аяны хүрээнд дунд, ахлах ангийн 9 бүлгийн 124 сурагчдад үе тэнгийн дээрэлхэлтийг таслан зогсоох, ялгаварлан гадуурхах үзэгдлийг бууруулах зорилгоор сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулав.	90	90
		-	Хүүхэд хамгааллын чиглэлээр зохион байгуулах нөлөөллийн ажлын төрөл	3			
		-	Зөвлөгөө, мэдээлэл авсан хүүхэд багачууд болон холбогдох сургалтад нийт хамрагдагсад	449			

					Тайлант хугацаанд 68 сурагч сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөнд хамрагдсан ба зөвлөгөөнд хамрагдсан нийт үйлчлүүлэгчдийн зонхилж буй асуудал нь Ye тэнгийн харилцаа дээрэлхэлт 15%, үерхэл, нөхөрлөл 10%, гэр бүлийн харилцаа (архины хамаарал, үл ойлголцох): 5%, бусад (зан үйлийн өөрчлөлт) 3 хувийг тус тус эзэлж байна. Мөн "No Smoke" хөнөөлийн арга хэмжээнд 13 ангийн 358 сурагчид идэвхтэй оролцон, цахим хуудсаар 14 видео контент, "Тамхинаас татгалцъя" сэдэвт гар зураг 95 сурагч зурж, постер танилцуулга бэлтгэж 31 эцэг эх, асран хамгаалагч, иргэн, 11 ААНБ-ыг татан оролцуулан олон нийтэд сурталчилж Like-2297, сэтгэгдэл-843, үзсэн 59263, нийт 62403 хүнд тамхины хор хөнөөлийн талаар мэдээлэл хүргэлээ. Гэр бүлийн зүгээс анхаарал халамж дутаж хараа хяналт суларснаас эрсдэлд өртөж болзошгүй 12, хүүхдийн хүмүүжил төлөвшил зан байдал эерэг хүмүүжлийн талаар 19 эцэг эх, асран хамгаалагчтай уулзаж зөвлөмж зөвлөгөө өгч ажилласан байна. Хэрэгжилтийн хувь 90		
33	Арга хэмжээ 3.3.20. ерөнхий боловсролын сургууль, дотуур байранд орчны эрсдэлийн үнэлгээг хийж, сургуулийн орчны аюулгүй байдлын стандарт, эрүүл ахуйн стандарт болон дотуур байрны орчин, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах;	-	Стандартын хэрэгжилт, хувь	100	Дүүргийн Засаг 2025 оны А/47 дугаар захирамжаар "Орчны аюулгүй байдлыг хангах, үзлэг шалгалт зохион байгуулах" ажлын дэд хэсгийг 13 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан 3 удаа хяналт шалгалтын ажил зохион байгуулан нийт 90 зөрчил үүнээс боловсролын байгууллагад 34 зөрчлийг илрүүлэн бүрттэлжүүлж чиг үүргийн байгууллагуудад албан бичгээр хүргүүлэн ажилласан ба 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 28 зөрчил арилгаад байна. Одоогоор СӨБ-32 камер, 17 гэрэлтүүлэг, ЕБС- 27 ширхэг камер, 19 ширхэг гэрэлтүүлэг ажиллаж байна. Дүүрэгт дотуур байр байхгүй болно. Хэрэгжилтийн хувь 82,3	82,3	82,3
		-	Орчны аюулгүй байдлыг хангах хяналт шалгалт	1			
		-	Зөрчил арилгалтын хувь	82,3			
34	Арга хэмжээ 3.3.21. ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол хүнсний чанар хүртээмжид хяналт тавих, орон нутгийн жижиг, дунд хүнс үйлдвэрлэгчдийг дэмжих, сургуулийн дэргэдэх туслах аж ахуйг хөгжүүлэх замаар захиалга, нийлүүлэлтийн нөөцийг бүрдүүлж үнийн тогтвортой байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх;	-	Бодлогын хэрэгжилт, хувь	100	Дүүргийн төрийн өмчийн 2 цэцэрлэг нь "Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага MNS 4946:2019" стандартын дагуу "Налайх хангамж" нийтлэг үйлчилгээний төв ОНӨААТҮГ-аас шинжилгээнд хамрагдсан шим тэжээллэг хүнсний бүтээгдэхүүнээр хүүхдийн хоолыг хангаж байна. Нийслэлийн ерөнхий боловсролын 91,94 дүгээр сургуулиуд нь Үдийн хоол хөтөлбөрт хэрэглэгдэх хүнсний бүтээгдэхүүнийг "Төрийн худалдан авах цахим дэлгүүр" Сүү ХК гэрээт борлуулагч ЭББББ Тайхар хайрхан дэлгүүрээс худалдан авалт хийж хүнсний бүтээгдэхүүн хүлээн авахдаа лабораторийн шинжилгээний үр дүн савлагаа үйлдвэрлэсэн оныг шалгаж, хяналт тавин ажиллаж байна. ЕБС-ийн Үдийн хоол хөтөлбөрт 436 сурагч, СӨББ-д 276	100	100

					суралцагч хамрагдаж байна. Хэрэгжилтийн хувь 100		
35	Арга хэмжээ 3.3.22. ерөнхий боловсролын сургуулийн дунд болон ахлах ангийн сурагчдад эрүүл мэндийг дэмжсэн "Өглөөний цай", "Сүү" хөтөлбөрийг орон нутаг болон эцэг эхийн оролцоотойгоор төсөв санхүүжилтийг шийдвэрлэн зохион байгуулах;	-	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувь	100	2024-2025 оны хичээлийн жилд төрийн өмчийн 2 цэцэрлэг "Налайх хангамж" нийтлэг үйлчилгээний төв ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан хүүхдүүдийн хоол, цайнд шинжилгээнд хамрагдсан шим тэжээллэг хүнсний бүтээгдэхүүн ашиглав. 2025-2026 оны хичээлийн жилд дүүргийн төсвөөс 31,104,0 сая төгрөг "СҮҮ" хөтөлбөрт тусгагдсан ба хөтөлбөрийн хүрээнд 7 хоногт 3 удаа 200г сүү өгөхөөс 2 өдрийг нь дүүргийн төсвөөс 1 өдрийг нь эцэг эх асран хамгаалагчаас гаргуулан "Сүү" ХК-ны 200гр сүүг 1-12-р ангийн 901 сурагчдад өгч байна. Тайлант хугацаанд эцэг эх асран хамгаалагчдаас 1,1 сая төгрөгийн дэмжлэг авч Сүү хөтөлбөрт зарцууллаа. Хэрэгжилтийн хувь 100	100	100
		31,4	Хөтөлбөрт хамрагдсан сурагчид	870			
36	Арга хэмжээ 3.3.23. багш, удирдах ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулах, орон сууцны болон нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр дэмжлэг үзүүлэх орон нутгийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	3,1	Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт хамрагдсан багш, удирдах ажилтан, тоо	20	Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2025 оны А/06 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг батлан хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчдыг гадаад, дотоодын сургалтад хамруулах чиглэлээр төсөв батлагдаад байна. Энэ хүрээнд Солонгос улсад зохион байгуулагдсан туршлага судлах, багшийг хөгжүүлэх, сургалтын үйл ажиллагаанд 44 дүгээр цэцэрлэгийн 2 багшийг хамруулж 3,1 сая төгрөг, Нийслэлийн Боловсролын газраас Япон улсад 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс 11 дүгээр сарын 02-ны өдрийн хооронд зохион байгуулагдсан Олон Улсын англи хэлний багш, мэргэжилтэн судлаач, оюутнуудад зориулсан "JALT-2025" чуулга уулзалтад дүүргийн 94-р сургуулийн Англи хэлний багшийг хамруулж 1.7 төгрөгийг тус тус зарцуулаад байна. Мөн дүүргийн түрээслээд өмчлөх байранд боловсролын байгууллагын 18 багш, ажилтан амьдарч байна. Хэрэгжилтийн хувь 90	90	90
37	Арга хэмжээ 3.3.24. сургуулийн гадна байгаа хүүхэд болон сургууль завсардсан хүүхэд, залуучуудад боловсрол нөхөн олгох, тэднийг ерөнхий боловсролын сургуульд шилжүүлэн суралцуулах ажлыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах;	-	Боловсрол нөхөн олгох сургалтад хамрагдсан хүүхэд, залуучууд	26	2025-2026 оны хичээлийн жилд хичээл завсардсан хүүхэд байхгүй бөгөөд завсардалтаас урьдчилан сэргийлж сургалтын менежер, нийгмийн ажилтан, анги удирдсан багш нар хичээлээс хоцордог, хичээл таслалттай завсардаж болзошгүй 9 сурагчийн эцэг эх, асран хамгаалагчтай хариуцлагын гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Насан туршийн суралцахуйн төвд 27 сурагч бүртгэгдэн боловсрол нөхөн эзэмших чиглэлээр суралцаж байна. Хэрэгжилтийн хувь 100	100	100

38	Арга хэмжээ 3.3.25. дүүрэгт бүртгэлтэй өвлөн уламжлагчдыг дэмжих, урамшуулах, хамтарч ажиллах;	3,1	Бүртгэлтэй өвлөн уламжлагчид, тоо	96	Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын судалгааг шинэчлэн www.ich.mongoluv.mn сайтад 96 иргэний мэдээллийг бүрэн оруулж баталгаажуулав. Соёлын биет бус өвийн 2024 оны хураангуй болон дэлгэрэнгүй тайланг гарган Нийгмийн хөгжлийн хэлтсийн даргын 2025 оны 07/345 дугаар албан бичгээр нийслэлийн Соёл Урлагийн газарт хүргүүлэв. Мөн 2025 оны 06 дугаар сард зохион байгуулагдсан " Иргэдийн баяр-Даншиг наадам"-д дүүргийн соёлын биет бус өв өвлөн уламжлагч 30 иргэнийг оролцуулж тус арга хэмжээнд 3,0 сая төгрөг зарцуулав. Нүүдэлчин фестивальд дүүргээс 10 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөл Нийслэлийн 9 дүүрэгтэй хамтран 1 баг болж оролцон тэргүүн байранд шалгарав. Мөн Нийслэлийн Соёл урлагийн газраас зохион байгуулсан нийслэлийн "Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөгөөнд 11 иргэнийг хамруулав. Хэрэгжилтийн хувь 100	100	100
39	Арга хэмжээ 3.3.26. дүүргийн хэмжээн дэх түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, иргэн аж ахуйн нэгжүүдэд гэрээгээр хариуцуулах ажлыг зохион байгуулах.	-	Дүүрэгт бүртгэлтэй үл хөдлөх дурсгалт зүйлс	44	Дүүрэгт бүртгэлтэй 44 түүх соёлын үл хөдлөх дурсгал байгаагаас нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор дүүргийн хамгаалалтад 2 дурсгал бүртгэлтэй байна. Нийслэлийн Соёл Урлагийн газраас Улсын хамгаалалтад бүртгэлтэй түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалтыг хариуцуулах гэрээг 2 дугаар хорооны ажлын албатай байгуулав. Үзлэг шалгалтыг 1 удаа зохион байгууллаа. Хэрэгжилтийн хувь 100	100	100
		-	Иргэн аж ахуйн нэгжүүдэд гэрээгээр хариуцуулах ажлын хэрэгжилт, хувь	100			
3.4.Дэд бүтцийн хүрээнд:							
40	Арга хэмжээ 3.4.1. нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд орчны 50м-ийн бүсэд цэвэрлэгээ, орох, гарах хэсгийн зам талбайг засварлуулах, орчны тохижилтыг сайжруулах, үүрэг өгч, хяналт тавьж ажиллах;	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Дүүрэгт тус онд зохион байгуулах бүх нийтийн их цэвэрлэгээний 6 заалт бүхий хуваарийг дүүргийн Менежерээр батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлангийн хугацаанд бүх нийтийн их цэвэрлэгээг 4 удаа зохион байгуулан давхардсан тоогоор 210 ААНБ, 975 ажилтан, албан хаагч болон иргэн оролцож 150268м^2 талбайн үүсмэл хог хаягдлыг цэвэрлэж 306,6тн хогийг төвлөрсөн хогийн цэгт буулгав. Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс болон 1,2 дугаар хорооны тохижилт, хог хаягдлын олон нийтийн байцаагч нар хяналт тавьж ажиллав. Хэрэгжилтийн хувь 90	90	90
			Орчны 50м-ийн цэвэрлэгээ хийсэн давтамж	4			
			Оролцсон ААНБ	146			
			Оролцсон ажилтан,	877			

			албан хаагч, иргэд				
			Талбайн хэмжээ ($м^2$)	146109			
			Хогны хэмжээ (тнн)	39,5			
41	Арга хэмжээ 3.4.2. инженерийн шугам, сүлжээ засварлах, шинээр татах зорилгоор нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг зөвшөөрөлгүй эвдэж, сүйтгэж байгаа үйлдлийг газар дээр нь илрүүлсэн тохиолдолд нийслэл рүү даруй мэдэгдэж, хороо, хэсгийн ахлагч нараар тогтмол хяналт тавиулах, зөрчил гаргасан аж ахуйн нэгж, иргэдийг Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээг авахуулах;	987,000	Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг эвдэж, сүйтгэсэн үйлдэл, тоо	-	Дүүргийн 1 дүгээр хорооны Өндөртолгой хотхоны хойд жигүүрийн халаалтын Ф-150, Ф-125 шугам болон Төв талбайн зүүн жигүүрийн шугам сүлжээнд хэрэглээний халуун усны Ф-50 шугамд гэмтэл гарч, түүнийг хэсэгчлэн сольж шугам сүлжээг хэвийн горимд оруулав. Тус ажлын хүрээнд явган замын хуулсан хавтан болон гаргасан шороог зөөж, хэвийн байдалд оруулсан. Мөн Багахангай тохижилт ОНӨААТҮГ-аар нийтийн эзэмшлийн талбайн явган замыг хуулж, ажил дууссаны дараа нөхөн засварлуулав. Тус ажлыг гүйцэтгэхэд Илч-Орд ОНӨААТҮГ-аас 987,000 төгрөг, 34 ажилтан, албан хаагчдад хууль, журмын дагуу илүү цагийн цалин хөлсийг бодож олгосон байна. Дүүргийн нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг зөвшөөрөлгүй эвдэж, сүйтгэсэн ААНБ болон иргэн байхгүй. Хэрэгжилтийн хувь 100	100	100
42	Арга хэмжээ 3.4.3. орон сууцны конторуудын үйл ажиллагаанд хяналт тавих, шугамын эзэлжит засвар, үйлчилгээг тогтмол хийлгүүлэхэд анхаарч, иргэд оршин суугчдын тав тухтай амьдрах нөхцөлийг хангаж ажиллах;	1,5	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Дүүрэгт орон сууцны конторын чиглэлээр үйл ажиллагааны аж ахуй нэгж байгууллага байхгүй болно. Дүүргийн хэмжээнд нийт 16 нийтийн эзэмшлийн орон сууцны байрыг хариуцан ажилладаг 3 сууц өмчлөгчдийн холбоо үйл ажиллагаа явуулж байна. Үүнд: 'Хангай өргөө' СӨХ нь 5 орон сууцны байр, 'Их хангай' СӨХ нь 11 орон сууцны байр, 'Баян хангай' СӨХ нь 1 орон сууцны байрыг тус тус хариуцан ажиллаж байна. Мөн дүүргийн 3аса даргын нөөц хөрөнгөөс иргэдийг ая тухтай амьдрах сууц өмчлөлийн холбоодын ажил арга хэмжээг дэмжих зорилгоор дүүргийн1,2 дугаар хорооны Их хангай СӨХ-т 1,6 саятөгрөг, Хангай өргөө СӨХ-т 2,1 сая төгрөгний засвар шинэчлэлийн ажилд 3,7 сая төгрөг зарцуулсан. Түүнчлэн дүүргийн СӨХ-уудын үйл ажиллагаар дэмжиж, өвөлжилтийн бэлтгэлийг сайжруулах зорилгоор "Дулаан өвөлд хамтдаа" болзолт уралдааныг зохион байгуулж 2025 оны 12 дугаар сарын 12-нд дүгнэн, 0.5 сая төгрөгийн шагналаар урамшуулахаар ажиллаж байна. Хэрэгжилтийн хувь 100	100	100

43	Арга хэмжээ 3.4.4. нутаг дэвсгэрийн авто замд байршуулсан нийтийн эзэмшлийн хайс хашлагыг угааж цэвэрлэх, эвдэрсэн даруйд арга хэмжээг авдаг байх;	80,0	Хайс хашлагыг угааж цэвэрлэсэн давтамж	4	Дүүргийн 1,2 дугаар хорооны нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн 1120м урт хайс, хашааг хуваарийн дагуу тогтмол тоос шороноос цэвэрлэж, угааж хэвшсэн бөгөөд дулааны улиралд 1–3 удаа угааж цэвэрлэгээ хийдэг. Мөн 25 м² эвдэрсэн хайс, хашааг засварлаж, /720м/ урт хайс, хашааг шинээр барьж мод, бут тарив. Түүнчлэн 300м хайс, хашааг будаж өнгө үзэмжийг сайжруулсан. Хэрэгжилтийн хувь 100	100	100
44	Арга хэмжээ 3.4.5. явган хүний нүхэн болон гүүрэн гарцын арчлалт, ашиглалтыг сайжруулахад хамтарч ажиллах;	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	100	Дүүргийн 1, 2 дугаар хорооны нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байрлах явган хүний замын эвдрэл гэмтлийг тухай бүр засварласан. Үүнд: ➢ Эко төгөлийн модон гүүр хүртэлх явган хүний зам, ➢ 1 р хорооноос ЗДТГазар хүртэлх чиглэлийн явах явган замын эвдрэлийг сэргээн засварласан, ➢ 1 дүгээр байрны урд тадлын явган хүний замын эвдрэл гэмтэл ➢ Нийслэлийн 91-р сургуулиас Илч орд ОНӨААТҮГхүртэлх 300м явган хүний замын засвар үйлчилгээ ➢ Дүүргийн 1 дүгээр хорооны Соёлын төвийн урд нийтийн эзэмшлийн 100м2 зам талбайн явган зам ➢ Дүүргийн 1 дүгээр хорооны 3 дугаар байрны урд 22м2, зүүн хойд тал 2м2, 44 дүгээр цэцэрлэгийн баруун урд тал 4м2, Илч-Орд ОНӨААТҮГ-ын баруун урд 100м2 явган зам хөрөнгө оруулалтын засварын ажлын дараах нийт 128м2 явган зам, 6м2 авто замын нөхөн сэргээлтийн ажил ➢ Төв талбайн шатны 3ш плита, цэцгийн мандалын 4ш плита унасанг наасан ➢ 2 дугаар хорооны 8, 12 дугаар байрны авто зогсоолын бордюурыг тэгшилсэн ➢ 1 дүгээр хороо 5 дугаар байрны авто зогсоолын хажуу 1м2 талбайн эвдрэл гэмтэл ➢ 1 дүгээр хорооны төв талбайн урд шонгийн хавтангуудыг тэгшлэж зассан ➢ 1 дүгээр хорооны 2 дугаар байрны урд явган хүний зам дээрх модны үндсийг тасдаж замтай нь тэгшлэж хавтан тавьсан 1 дүгээр хорооны Үнэгтэй гэр хорооллын 1.2 км авто зам дагуух шороог авсан, 1, 2 дугаар хорооны төв талбайн унасан, хагарсан эвдрэл гэмтлийг шавардаж нөхөн сэргээж тухай бүр засварлаж байна. Хэрэгжилтийн хувь 90	90	90
45	Арга хэмжээ 3.4.6. хот нийтийн "Ulaanbaatar Engineering"	-	Системийн хэрэгжилт,	-	УБЗАА-наас зохион байгуулсан "Ulaanbaatar Engineering" Улаанбаатар хотын инженерийн дэд бүтцийн нэгдсэн хяналт,	-	-

	Улаанбаатар хотын инженерийн дэд бүтцийн нэгдсэн хяналт, удирдлагын цогц системийн үйл ажиллагааг бүрэн нэвтрүүлэн, мэдээллийн сангийн баяжилтыг тогтмол мэдээллээр ханган ажиллах;		хувь		удирдлагын цогц системийн сургалтад холбогдох мэргэжилтэн хамрагдсан. Тус дүүрэг одоогоор мэдээллийн сангийн баяжилтад хамрагдаагүй байна. Хэрэгжилтийн хувь -		
46	Арга хэмжээ 3.4.7. халиа дошин, шар усны үерийн нөхцөл байдалд хариу арга хэмжээг Нийслэлийн Захирагчийн ажлын албатай уялдуулан зохион байгуулж шар усны үерт өртөх эрсдэлтэй байршилд газар олголт хийхгүй байх, шар усны үер, халиа дошинд өртөх эрсдэлтэй байршлыг иргэдэд тогтмол сэрэмжлүүлж ажиллах;	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	100	Дүүргийн "Үер усны ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ"-ний төлөвлөгөөний дагуу байршилд / 1 дүгээр хороо Аэродромын баруун тал , 2 дугаар хороо Уурхайн карьерт байршуулсан.Дүүргийн Онцгой байдлын хэлтэс, гал түймэр унтраах, аврах 80 дугаар ангийн бэлтгэл зэлжийн давхардсан тоогоор 147 алба хаагч дүүргийн 1, 2 дугаар хороонд байрлах нуур, тогтоол ус, карьер орчимд иргэд усанд осолдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор хөдөлгөөнт эргүүлийг нийт 42 удаагийн эргүүл, шалгалтыг зохион байгууллаа. Дүүргийн нутаг дэвсгэрт томоохон гол, мөрөн, гүүр, гарам байхгүй болно. Тус арга хэмжээний хүрээнд иргэд хараа хяналтаа сулруулахгүй байж бага насны хүүхдэд тавих хараа хяналтыг сайжруулах, үер усны ослоос урьдчилан сэргийлэх талаар 126 иргэнд усны ослоос урьдчилан сэргийлэх, бага насны хүүхдээ хараа хяналттүй нуур, тогтоол усны ойролцоо тоглуулахгүй байх талаар сэрэмжлүүлэг, ухуулга яриа хийж, 113 ширхэг гарын авлага материал хүргүүлсэн. Үерт өртөх эрсдэлтэй 26 айл өрхийн 86 иргэдэд 105 ширхэг үерийн ослоос урьдчилан сэргийлэх гарын авлага хүргүүлж заавар зөвлөгөө өгч ажиллалаа. Үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх "Сэргийлье-Сэрэмжилье II" нэгдсэн арга хэмжээний хүрээнд дүүргийн нуур, тогтоол ус, карьерын эрэг дагуу 2025 оны 07 дугаар сарын 11-ний өдөр 2 самбар шинэчлэн байршуулж, Багахангай дүүрэг Онцгой байдлын хэлтэс пейж хуудаст 5 мэдээ, мэдээлэл байршуулан 161 иргэн олон нийтэд хүргэж ажиллалаа. Цаг уур, орчны шинжилгээний газраас сэрэмжлүүлийг Багахангай дүүрэг Онцгой байдлын хэлтэс пейж хуудаст 12 мэдээ, мэдээлэл байршуулан 236 иргэн олон нийтэд хүргэн ажиллалаа. Хэрэгжилтийн хувь 90	90	90
47	Арга хэмжээ 3.4.8. нийслэлийн иргэдийг үер, усны болзошгүй аюулаас урьдчилан сэргийлж, хамгаалах, бүтээн байгуулах, үерийн хамгаалалтын далан, суваг, зам, талбайн борооны ус зайлуулах шугам, хөрсний усны шугамын	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	90	Дүүргийн нутаг дэвсгэрт үер, усны болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүллээ. Хангайн парк 1-ийн орох замд байрлах 4м урттай модон гүүрийг засварлаж, мөн Биеийн тамир, спорт хорооноос 6 дугаар байр хүртэлх 400м урт үерийн даланд 36м² талбайд засварын ажил хийв. Түүнчлэн дүүргийн хороодыг холбосон авто замын дагуух үерийн суваг, шуудууны 30м² эвдэрч гэмтсэн хэсгүүдийг	100	100

	хэвийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор усны барилга байгууламжийн мэргэжилтэнд хариуцуулж, үерийн хамгаалалтын далан, сувгийн цэвэрлэгээ, арчилгааг тогтмол хийж, ус чөлөөтэй нэвтрэх бэлэн байдлыг хангаж ажиллах.				засварлаж, бүрэн ажиллагааг хангаж ажиллалаа.Үерийн хоолой, суваг шуудууг тогтмол сэтлэн цэвэрлэх, үйлчилгээ хийх ажлыг тасралтгүй зохион байгуулж, тухайн чиглэлийн засвар, нөхөлт болон модон гүүрийн шинэчлэлийн ажилд нийт 8.7 сая төгрөг зарцуулсан. Мөн үерийн далангийн түүвэр цэвэрлэгээг Биеийн тамир, спорт хорооноос 6 дугаар байр хүртэлх 400м² талбайд, хороодыг холбосон зам дагуух 450м² талбайд тогтмол хийж, нийт 27.5 тонн хог хаягдлыг түүж, төвлөрсөн хогийн цэгт хүргэн ажиллав. Хэрэгжилтийн хувь 90		
3.5.Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн хүрээнд:							
48	Арга хэмжээ 3.5.1. Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд ирж байгаа өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг сайжруулж, иргэдээс харьяаллын дагуу ирсэн өргөдөл, гомдолд дурдсан асуудлыг эрх хэмжээнийхээ хүрээнд бүх талаас нь судлан үзэж, шуурхай, хуулийн хугацаанд, үндэслэлтэй хариу өгч, бүрэн барагдуулж шийдвэрлэх;	-	11-11 төвөөр дамжуулан ирсэн нийт өргөдөл, гомдол, тоо	12	Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан дүүрэгт 29 өргөдөл ирснээс 5 хүсэлт, 4 гомдол, 19 талархал байна. Иргэдээс ирүүлсэн 4 гомдлыг бүрэн барагдуулж, иргэнд албан бичгээр хариуг хүргүүлэн ажиллалаа. Хэрэгжилтийн хувь 100	100	100
49	Арга хэмжээ 3.5.2. иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг бүртгэж, шилжүүлэх үйл явцын зөрчлийг арилгах, шат дамжлага, шийдвэрлэлтийн хугацааг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгай төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг үр дүнтэй хангаж хугацааг 2 дахин бууруулах;	- -	Өргөдөл гомдлын шийдвэрлэлт, хувь Шийдвэрлэлтийн дундаж хугацаа	95 4 хоног, 20 цаг	Иргэдээс дүүргийн нутгийн захиргааны 21 байгууллагад нийт 322 өргөдөл ирснээс 322 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлт 100%-тай, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3 хоног 19 цаг 1 минут байна. Иргэдээс ирүүлсэн өргөдөлд хууль зүйн үндэслэлийг тусган, 32 өргөдлийн хариуг иргэнд албан бичгээр, 228 өргөдлийн хариуг иргэнд биечлэн хүргэж, 62 өргөдлийн хариуг утсаар өгч ажиллалаа. Иргэний талд шийдвэрлэсэн 258 өргөдөл, боломжгүй хариу өгсөн 63 өргөдөл байна. Шийдвэрлэлтийн дундаж хоног өмнөх оныхоос 1 хоногоор буурсан үзүүлэлттэй байна. Хэрэгжилтийн хувь 100	100	100
50	Арга хэмжээ 3.5.3. иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлээгүй, шийдвэрлэх явцад ёс зүйн зөрчил гаргасан, тайлан мэдээг дээд шатны байгууллагад хугацаанд нь хүргүүлж ажиллаагүй албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасны дагуу хариуцлага	-	Нийт зөрчил	76	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад 11 байгууллага 27 зөрчил гаргасан байна. Зөрчил гаргасан 11 байгууллагын 14 албан хаагчаас тайлбар мэдээллийг бичгээр авч, НЗДТГ-т 7 хоног бүр хүргэн, цаашид өргөдлийг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэхгүй байх, шийдвэрлэлтийн явцад зөрчил гаргахгүй байхад анхаарч ажиллахыг үүрэг чиглэл болгов. Мөн зөрчил гаргасан аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарын 2025 оны хагас жил болон жилийн эцсийн ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ тус бүр зөрчлийн тоогоор оноо хасч ажлыг үнэлж дүгнэсэн болно.	100	100

	тооцож, сахилга, хариуцлагыг чангатгах;				Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дүгээр захирамжаар шинэчлэн батлагдсан журмын дагуу улирал бүр тайланг гаргаж холбогдох газарт хүргүүлж байна. 2025 оны хагас жилийн тайланг ЗДТГ-ын 2025.06.26-ны өдрийн 05/506 дугаар албан бичгээр, 2025 оны 3-р улирлын тайланг 2025.09.30-ны өдрийн 2025.09.30-ны өдрийн 05/678 дугаар албан бичгээр НЗДТГ-ын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд тус тус хүргүүлэв. Хэрэгжилтийн хувь 100		
51	Арга хэмжээ 3.5.4. иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг бүрэн барагдуулж шийдвэрлэх, өмнөх оноос гомдлын тоог 30-иас доошгүй хувиар бууруулах;	-	Иргэдээс гаргасан гомдлын бууралтын хувь	22	Дүүргийн хэмжээнд нутгийн захиргааны байгууллагаар 9, Засгийн газрын 11-11 төвөөр 4, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан 1, нийт 7 гомдол ирүүлсэн байна. Үүнд: Засаг дарга болон ЗДТГ-т хандан 6, Нийгмийн даатгалын газарт 1, Цагдаагийн хэлтэст 1, Эрүүл мэндийн төвд 2, Газар зохион байгуулалтын албанд 4, нийт 14 гомдол иргэдээс гаргасан байна. 14 гомдлыг хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэж, иргэнд хариуг албан бичгээр хүргүүлэн ажиллав. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гомдлын тоо 17%-аар буурсан үзүүлэлттэй байна. Хэрэгжилтийн хувь 77,3	77,3	77,3
52	Арга хэмжээ 3.5.5. дүүрэг, түүний харьяа байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг мэргэжлийн байгууллагаар улирал бүр хийлгүүлж, дүнг үндэслэн цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх.	5,0	Мэргэжлийн байгуулагаар хийлгэсэн сэтгэл ханамжийн судалгаа, тоо	-	Дүүргийн хэмжээнд төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын зүгээс авч хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаатай холбоотой иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлох, дүгнэлт хийх зорилгоор Хэрэглэгчийн үнэлгээг "Менежмент ба ур чадварын хүрээлэн" НҮТББ-аар 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хооронд гүйцэтгүүллээ. Тус байгууллага нь гэрээнд заасны дагуу сэтгэл ханамжийн судалгааны ажлын тайланг ирүүлсэн. Хэрэгжилтийн хувь 90	90	90
3.6.Хотын хөгжлийн индексийн хүрээнд:							
53	Арга хэмжээ 3.6.1. Хотын хөгжлийн индексийн үзүүлэлтээс Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Бодлогын судалгаа шинжилгээний төвтэй хамтран өөрийн байгууллагын хариуцах индексийн үзүүлэлтийг тогтох, индексийн суурь түвшинг нягтлах, сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлыг 2025 онд багтаан хийж гүйцэтгэх;	-	Дүүрэг хариуцах индексийн үзүүлэлтийн төрөл	86	Нийслэлийн холбогдох байгууллагаас одоогоор төлөвлөгөөний төсөлд санал аваагүй болно.	-	-
54	Арга хэмжээ 3.6.2. Хотын хөгжлийн индексийн өөрийн байгууллагын хамаарах үзүүлэлтийг сайжруулах	-	Төлөвлөгөө-ний хэрэгжилт,	90	Дүүргийн хэмжээнд хотын хөгжлийн индексийн суурь түвшинг нягтлах, сайжруулах хүрээнд хороодын Засаг дарга, хэсгийн ахлагч, нийгмийн ажилтнуудыг оролцуулан хамтарсан хурлыг	70	50

	үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж, хүрсэн үр дүнг 2025 оны жилийн эцсийн байдлаар шинэчлэн тооцох ажлыг зохион байгуулах;		хувь		тайлант хугацаанд 1 удаа зохион байгуулав. 2025 оны эхний хагас жилийн байдлаар дүүргийн 1 дүгээр хорооноос шивэлт хийгдээгүй 2023, 2024 онууд болон 2025 оны 58 маягт, 2 дугаар хорооноос шивэлт хийгдээгүй 2023, 2024 онууд болон 2025 оны 22 маягт буюу нийт 80 маягтыг нөхөн шивж оруулах үүрэг чиглэлийг холбогдох ажилтнуудад өгч ажилласны дагуу 1, 2 дугаар хорооны холбогдох албан хаагчид шивэлтийг бүрэн гүйцэтгэж, Хотын хөгжлийн индекс тооцох аргачлал батлах тухай А/77 дугаар тушаалын дагуу холбогдох маягтаар гарган Happycity.mn сайтад шивэлт хийсэн. Хэрэгжилтийн хувь 70		
55	Арга хэмжээ 3.6.3. Хотын хөгжлийн индекс болон тухайн байгууллагын суурь мэдээллийг орон зайд суурилсан нийслэлийн дундын мэдээллийн санд тухай бүр оруулж ажиллах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	90	Дүүргийн 1, 2 дугаар хорооны нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч нар нь Хотын хөгжлийн индекс тооцох аргачлал батлах тухай А/77 дугаар тушаалын дагуу холбогдох маягтаар үзүүлэлтийг гарган 2025 оны дутуу шивэлт хийгдсэн маягтуудыг нөхөж байршуулсан. Хэрэгжилтийн хувь 90	90	70
3.7.Хот нийтийн аж ахуйн хүрээнд:							
56	Арга хэмжээ 3.7.1. мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд орж ирсэн адуу малыг гаргах, хашаанд түр саатуулах, эзэнд хүлээлгэж өгөх үйл ажиллагаа (Холбогдох журмын хүрээнд);	30,0	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Дүүргийн Засаг даргын 2025 оны А/28 дугаар захирамжаар Мал аж ахуйн эрхлэхийг хориглох бүсэд байгаа малыг нүүлгэн шилжүүлэх дэд ажлын хэсэг 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдав. Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд 2024 оны 03/706 дугаар албан бичгээр хүсэлт хүргүүлсэн бөгөөд 1 дүгээр хороонд Багахангай мах боловсруулах үйлдвэрийн хойд талд 4913м^2 газар, 2 дугаар хороонд 9 дүгээр байрны баруун талд 1941м^2 тус тус байршуулан Багахангай гэрэлтүүлэг ногоон байгууламж ОНӨААТҮГазар хариуцан ажиллаж байна. Тайлангийн хугацаанд 2 удаа 4 өрхийн 88 толгой мал хориглосон бүсэд бэлчсэн малыг хашаанд хашиж, дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн хэлтэс, 1 дүгээр хорооны ажлын албанд мэдэгдэн холбогдох эзэнд хүлээлгэн өгч заавар, зөвлөмж өгч ажиллав. Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүс дэх суурин малтай 27 өрхийн 600 толгой үхрээс 13 өрхийн 418 толгой үхэр мал гаргав. Хэрэгжилтийн хувь 70	70	70
			Хориглосон бүс дэх мал, амьтан	184			
			Түр саатуулах хашаанд хашаалсан мал амьтан	-			
			Мал, амьтныг хашаалснаас үүссэн төлбөр, хураамж	-			
57	Арга хэмжээ 3.7.2. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж (Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол) дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд мод тарьж, арчилж, ургуулах ажлыг нарийвчилсан судалгаа, төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулж, мод тарих үйл	14,8	Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хувь	100	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн ногоон байгууламжийн 2025 оны ажлын хуваарийг дүүргийн Менежерээр батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ нь нийтийн эзэмшлийн 9,3 га талбай бүхий ногоон байгууламжийн 38900ш мод, бут сөөг, 47 ш савтай мод 2500 м^2 зүлэгт талбай, 10 ш цэцгийн мандал, 2 ш цэцэгт байгууламжийн 7000 ш цэцгийн арчилгааг хариуцан ажиллаж байна. Тайлангийн хугацаанд батлагдсан хуваарийн дагуу усалгаа хийж,	90	90
			Тарьж ургуулсан мод	1500			
			Оролцсон өрх	424			

	ажиллагаанд хувийн хэвшил, иргэд, олон нийтийг оролцуулан мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;		Оролцсон ААНБ	35	бүх нийтийн цэвэрлэгээ, түүвэр цэвэрлэгээг давхардсан тоогоор 12 удаа, сардаа 2-3 тн хог, өнжмөл өвсийг хогийн цэгт хүргэж, хэлбэржүүлэлт, нөхөн тарилтын ажил хийгдэв. Дүүргийн 1, 2 дугаар хороог холбосон авто замын дагуу 0,3 га талбай бүхий хайс хашаанд 200 ш улиас, 500 ш голт бор, Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн авто замын дагуу 1,1 га талбайд, 1 дүгээр хорооны ногооны талбайн 0,27 га талбайд 1000 ш агч модыг тус тус тарьсан. Түүнчлэн 1800 м^2 талбай бүхий зүлэгт талбай, 3 ш цэцэгт байгууламж байгуулах ажлуудыг гүйцэтгэхэд 14,8 сая төгрөг зарцуулав. Түүнчлэн "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд дүүргийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 424 өрх, 35 аж ахуйн нэгж байгууллага агч, голт бор, монос, улиас гэсэн 4 нэр төрлийн нийт 1900 ширхэг мод тарьсан. Хэрэгжилтийн хувь 90		
58	Арга хэмжээ 3.7.3. дүүргийн нутаг дэвсгэрт тэжээвэр амьтны тооллого бүртгэлийг зохион байгуулах;	3,9	Тооллого бүртгэлийг зохион байгуулсан давтамж	1	Дүүргийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/203 дугаар захирамжаар 2024 оны "Мал, тэжээвэр амьтдын тооллого явуулах" комиссыг 6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, хороодод салбар комисс байгуулан 2024 оны 12 дугаар сарын 7-17-ны өдрүүдэд дүүргийн хэмжээнд "Мал, тэжээвэр амьтдын тооллого"-ыг зохион байгуулсан. Дүүргийн хэмжээнд 262 малчин өрхийн нийт 30243 толгой мал тоологдсон. Үүнд: адуу 4901, үхэр 3128, тэмээ 8, хонь 13659, ямаа 8332, гахай 13, нохой 176, муур 26 тоологдсон байна. Тус арга хэмжээнд дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 3,895,000 төгрөг зарцуулав. Нийслэлийн Засаг даргын А/764 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын А/114 дүгээр захирамж 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг малын түүвэр судалгаанд 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулав. Тооллогын түүвэр хүрээгээр 53 өрх сонгогдсон бөгөөд судалгааны хамралт болон шивэлтийг тооллогыг 100%-ийн гүйцэтгэлтэйгээр дуусгасан. Дүүргээс 2 тоологч оролцож 53 өрхийн 6304 толгой мал тоологдов. Тооллогын хяналтаар Нийслэлийн статистикийн газрын Эдийн засгийн статистикийн хэлтсийн дарга Ө.Нямжаргал, ахлах мэргэжилтэн З.Халиун нар 06 дугаар сарын 09-ний өдөр дүүрэгт ажиллаж 2 хорооны 4 өрхөөр орж, тоологч нарын тоолох явц, маягт хөтлөлт, тооллогын дараах хяналт тавьж ажиллав. Мал тооллогын программд малын тоог хугацаанд нь шивж оруулав. 2025 оны жилийн эцсийн дүүргийн нутаг дэвсгэрт тэжээвэр амьтны тооллого бүртгэлийг зохион байгуулахаар дүүргийн Засаг даргын захирамжийн төсөл боловсруулагдаж байна.	100	100
		-	Бүртгэгдсэн тэжээвэр амьтад	127			
59	Арга хэмжээ 3.7.4. эзэнгүй нохой, муурын тоо толгойг бууруулах	4,2	Нохой, муур устгалын	4	Анчин иргэн Н.О-той Эзэнгүй нохой, муур устгах ажлын гэрээ байгуулан 2025 онд 2, 5, 8,10 дугаар саруудад нийт 4 удаа	100	100

	ажлыг зохион байгуулах, буудаж устгахаас бусад арга хэрэгслийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх;		ажлыг гүйцэтгэсэн давтамж		устгалын ажлыг зохион байгуулж, нохой -240, муур-69-г устган тухай бүр төвлөрсөн хогийн цэгт булж, ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийн ажилласан. Зардалд 7,428,000 төгрөг зарцуулсан. Хэрэгжилтийн хувь 100		
			Устгагдсан муур, нохой, тоо	309			
60	Арга хэмжээ 3.7.5. хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэх;	23,3	Хог хаягдын хураамжаас төвлөрсөн орлого бүрдүүлэлт, хувь	100	Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/15 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган 65 аж ахуйн нэгж, байгууллага, 2 дугаар хорооны 540 айл өрхтэй гэрээ байгуулан өмнөх оны өр төлбөр, тайлант хугацааны төлбөрийг барагдуулан ажиллав. Жилийн төлөвлөгөөгөөр 70,0 сая төгрөг төвлөрүүлэхээс 10 дугаар сарын 30-ны байдлаар 51,4 сая төгрөг буюу 81,5 хувийн орлого төвлөрүүлсэн. Үүнээс 22,3 сая төгрөг нь давхардсан тоогоор 151 аж ахуйн нэгж, байгууллага, 29,0 сая төгрөг нь 1574 айл өрхийн төлбөр байна. Байгууллагын өөрийн орлого 9,5 сая төгрөг байна. Хэрэгжилтийн хувь 100	100	100
61	Арга хэмжээ 3.7.6. нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээ, айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын хог тээврийн үйлчилгээний ажлыг зохион байгуулах;	-	Нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ-ний давтамж	4	Багахангай тохижилт ОНӨААТҮГ нь дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 150,508м^2 талбайг хариуцан, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмолжуулан тайлангийн хугацаанд 1, 2 дугаар хорооны нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн эд хогшлийн угаалга, ариутгал халваргүйжүүлэлт, цэвэрлэгээний ажлыг 8 удаа гүйцэтгэсэн. Тус онд нийтийн эзэмшлийн зам талбайн эд хөрөнгийн арчлалт хамгаалалт, цэвэрлэгээ үйлчилгээг дараах байдлаар хийж ажилласан байна. - Дүүргийн 1, 2 дугаар хорооны нийтийн эзэмшлийн талбайн нийт 50 ширхэг сандалын эвдрэл гэмтлийг тухай бүр засварлан, ариутгал угаалга, будаг, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж, 2025 онд 1,415,000 төгрөг зарцуулсан. - Дүүргийн 1, 2 дугаар хорооны хүүхдийн тоглоомын талбай, нийтийн эзэмлийн зам талбайн 60 ширхэг хогийн савны эвдрэл гэмтлийг тухай бүр засварлан, ариутгал угаалга, будаг, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж, 1,595,500 төгрөг зарцуулсан. - Шинээр 4 байршилд ангилан ялгах зориулалт бүхий 4 ширхэг хогийн сав байрлуулж, 6,200,000 төгрөг зарцуулсан. Нийтийн эзэмшлийн гудамж, зам тайлбайн цэвэрлэгээг 2025 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 26 удаа зохион байгуулж, 231 тн хог хаягдлыг цэвэрлэн нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлсэн. Тус онд хар цас цэвэрлэгээгээр 76 тонн цасыг ачиж тээвэрлэн асгаснаас гадна ААНБ, НЭОС-ны айл өрхүүдийн ахуйн хог	100	100
		-	Хог тээврийн ажлын давтамж	-			
		-	Тээвэрлэсэн хогны хэмжээ (тнн)	10000			

					хаягдлыг 7 хоног бүр, гэр хорооллын ахуйн хог хаягдлыг өвлийн хуваарийн дагуу 7 хоногт 1 удаа, зуны хуваарийн дагуу 14 хоногт 1 удаа зохион байгуулж, 2025 оны эхний 11 сарын байдлаар НЭОС-ны айл өрхийн- 7578 тн, ААНБ- 1741 тн, гэр хорооллын айл өрхийн- 5423 тн, түүвэр цэвэрлэгээгээр- 231 тн буюу нийт 14973 тн хог хаягдыг тээвэрлээд байна. Хэрэгжилтийн хувь 100		
62	Арга хэмжээ 3.7.7. нийтийн бие засах газрын хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах;	274,0	Нийтийн бие засах газрын ашиглалт, хүртээмж, хувь	100	Халуун усанд орох үйлчилгээ болон саунд үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд нийцсэн бараа бүтээгдэхүүн, ахуйн хэрэглээний зүйлсийг худалдаалах үйлчилгээ нэвтрүүлсэн. Банкны картаар төлбөр тооцоо хийх боломж бүрдүүлж, НӨАТ-ын баримт олгож байна. Үйлчлүүлэгчдийг урамшуулах хүрээнд "5 удаа усанд орвол 1 удаа үнэгүй үйлчлүүлэх" хөнгөлөлтийн урамшууллын хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Мөн хэрэглэгчидтэй холбогдох тусгай утасны дугаар ажиллуулж, санал хүсэлт хүлээн авах, үйлчилгээний талаар мэдээлэл өгөх боломжийг бүрдүүлэв. Иргэдэд бие засах үйлчилгээг үнэгүй ашиглуулж байна. Хэрэгжилтийн хувь 90	90	100
63	Арга хэмжээ 3.7.8. согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эрх шилжсэнтэй холбогдуулан аж ахуйн нэгжээс ирүүлсэн хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шуурхай шийдвэрлэж хариу хүргүүлэх, тайлан мэдээг улирал бүр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлэх;	 -	Хууль тогтоомжийн хэрэгжилт, хувь Тусгай зөвшөөрөл олгогдсон ААНБ, тоо	100 12	Дүүрэгт Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл 12 аж ахуйн нэгж, байгууллагын 14 цэгт олгож үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Засаг даргын 2025 оны А/714, А/745 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд гар дээрээс болон зөвшөөрөлгүй, чанар стандартын шаардлага хангаагүй, татварын акцгүй согтууруулах ундаа худалдан борлуулж байгаа эсэх, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Холбогдох байгууллагуудтай хамтран 12 аж ахуйн нэгжид давхардсан тоогоор 9 удаа үзлэг, шалгалтын ажлыг зохион байгуулан зөвлөмж, чиглэл өгч ажиллав. УБЗАА-ны Хүнс, худалдаа, үйлчилгээний газарт судалгаа, мэдээлэл бэлтгэн холбогдох мэргэжилтэд 4 удаа (ERP-цахим)-аар хүргэн ажиллав. Хэрэгжилтийн хувь 90	90	90
64	Арга хэмжээ 3.7.9. нийслэлийн хүн амын хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан бэлтгэсэн нөөцийн мах худалдан борлуулах дэлгүүрийн судалгааг гаргаж, холбогдох байгууллагуудтай хамтран мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, бэлтгэл ажлыг ханган, худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллах;	-	Ажлын гүйцэтгэл, хувь Нөөцийн мах худалдан борлуулж буй дэлгүүр Худалдан борлуулсан давтамж Худалдан	100 3 4 12	Дүүрэгт нөөцийн мах худалдан борлуулж буй Хангайн булаг ХХК, Сэтгэлийн гэгээ ХХК, Буянт хангай булаг ХХК-ны 3 дэлгүүрийн үйл ажиллагаанд ТХҮХ, дүүрэг дэх Мал эмнэлгийн тасаг, Татварын Улсын байцаагч нартай хамтран нөөцийн махны жижиглэн худалдаанд 4 удаа хяналт тавьж ажиллав.Чойбалсан групп ХХК-ны бэлтгэн нийлүүлсэн үхэр, хонь, ямааны нөөцийн махны өргөтгөсөн худалдааг УБЗАА-наас батлагдсан байршлын дагуу 4 удаа зохион байгууллаа. Хонь , ямаа 396 ш гулууз 9,8 тн мах, үхрийн мах жижиглэнгээр 2,2 тн мах, нийт 12,0 тн махыг дүүргийн 1, 2-р хороонд худалдалдан 131,5 сая төгрөгийн борлуулалт хийв.	90	90

			борлуулсан махны хэмжээ (тнн)		Хэрэгжилтийн хувь 90		
65	Арга хэмжээ 3.7.10. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан "Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам"-ын хэрэгжилтийг дүүргийн нутаг дэвсгэрт хангуулж, хагас, бүтэн жилээр тайлагнах;	-	Журмын хэрэгжилт	100	Зөвшөөрлийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, энгийн болон тусгай зөвшөөрөл олгосон захирамж, зөвшөөрөл эзэмшигчдийн нэгдсэн судалгааг цахим сайтад байршуулсан. Дүүрэгт үйл ажиллагаа эрхэлж буй худалдаа үйлчилгээ, хоол үйлдвэрлэл эрхлэгчдэд ЗДТГ, НХХААГ, дүүргийн Насан туршийн суралцахуйн төв, Онцгой байдлын хэлтэстэй хамтран "Худалдаа үйлчилгээний байгууллагын соёлыг дээшлүүлэх нь" сэдэвт сургалтыг Иргэний танхимд зохион байгуулж, худалдаа үйлчилгээний байгууллагын нийт 36 төлөөллийг оролцуулав. Дүүргийн Засаг даргын 2025 оны А/83 дугаар захирамжаар "Улирлын чанартай хоол үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлүүлэх тухай" байршлыг шинэчлэн баталгаажуулан ://www.bagakhangai.ub.gov.mn/ сайтад байршуулан иргэдэд мэдээлэл хүргэв. Хурлаар Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх хүсэлтийг www.e-business.mn, www.e-mongolia.mn-ээр хүсэлтийг хүлээн авч, холбогдох хууль тогтоомж, баримт бичгийн бүрдэл хангасан 2 аж ахуйн нэгжид тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгосон Улсын тэмдэгтийн хураамжаар 500,000 төгрөгийн татварын орлого бүрдүүлэн ажилласан. Дүүргийн Цагдаагийн хэлтсээс Монгол Улсын Тамхины хяналтын тухай хууль зөрчиж, хууль бусаар тамхи худалдаж байсан иргэний зөрчлийг шалгаж, хураасан 14 нэр төрлийн 176 ширхэг эд зүйлийг үнэлгээний хамт дүүргийн Засаг даргын 2024 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан Орон тооны бус зөвлөлд хүлээлгэн өгөв. Ажлын хэсэг 2 төрлийн 49 ширхэг хайрцаг тамхийг устгах ажлын хэсэгт, 12 нэр төрлийн 127 ширхэг хайрцаг тамхийг худалдан борлуулах ажлын хэсэгт тус тус хүлээлгэн өгч ажиллав Устгалын ажлын хэсэг Илч-Орд ОНӨААТҮГ –ын халаалтын зууханд устгалын ажлыг зохион байгуулав. Тамхи худалдах зөвшөөрөлтэй Хангай булаг ХХК-нд тамхийг борлуулан 411,200 төгрөгийг (Төрийн сангийн 100200800955 данс)-нд төвлөрүүлсэн. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн "Худалдаа, үйлчилгээний төрөл, ангилал, худалдаа үйлчилгээ эрхлэхэд тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүргийг тодорхойлсон нийтлэг журам", дүүргийн вэйб сайт Засаг даргын Тамгын газрын пейж хуудас, хороодын цахим хуудсуудаар дамжуулан иргэн, аж ахуйн нэгжид мэдээлэл хүргэж ажиллав. Хэрэгжилтийн хувь 90	90	90
66	Арга хэмжээ 3.7.11. нийтийн	-	Гудамж, зам	4	Дүүргийн 1, 2 дугаар хорооны нийтийн эзэмшлийн гудамж, зам	100	100

	эзэмшлийн гудамж, зам, талбайн цэвэрлэгээ, хог тээвэрлэлтийн ажлыг хийж гүйцэтгэх;		талбайн цэвэрлэгээ Хогны хэмжээ (тнн)	 1800	талбайн 150568м2-ын эд хогшлийн угаалга, ариутгал халваргүйжүүлэлт 10, цэвэрлэгээг 4 удаа хийж гүйцэтгэсэн. "Цагаан сарыг угтсан бүх нийтийн их цэвэрлэгээ", "Бүх нийтийн их цэвэрлэгээ", "Хаврын их цэвэрлэгээ-ний хүрээнд явган зам, хөшөө дурсгал, сандал, хогийн сав, тоглоом зэргийг тусгай зориулалтын техөөрөмжөөр угааж ажилласан. Дүүргийн 1, 2 дугаар хорооны нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байрлах автобусны зогсоол-2, сандал-87ш, цинкэн хогийн сав-21ш, жижиг хогийн сав-70 ширхэгийг тогтмол суллаж, хуваарийн дагуу 20 удаа угааж, цэвэрлэн ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж, 8ш хогийн савыг татав авсан. 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр "Хунт хайрхан" ХХК-тай хамтран 1, 2 дугаар хорооны дараах байршлуудад халдваргүйжүүлэлт хийж ажиллав. Үүнд: Төв талбай, НЭОС-ны дундах хогийн бункерууд, гэр хорооллын хүүхдийн тоглоомын талбай, НЭОС-ны дундах хүүхдийн тоглоомын талбай, хөл бөмбөгийн талбай зэрэг нийт олон нийтийн хэрэглээний талбайнууд багтсан. Хэрэгжилтийн хувь 90		
67	Арга хэмжээ 3.7.12. нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн ногоон байгууламжийн арчилгаа, бүтээн байгуулалтыг нэмэгдүүлэх;	- -	Ажлын хэрэгжилтийн хувь Ногоон байгууламж бүхий талбайн хэмжээ	100 $м^2$	Дүүргийн 1,2 дугаар хорооны нийтийн эзэмшлийн ногоон байгууламж 10,1га талбайд жилийн 4 улирал арчилгаа хамгаалалт хийж ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 800$м^2$ талбай бүхий зүлэгт талбай, 3ш цэцэгт байгууламж байгуулсан. Мөн Тэрбум мод" хөтөлбөрт 1,2 хороог холбосон авто замын дагуу 0,3 талбай бүхий хайс хашаанд 200 ширхэг улиас, 500 ширхэг голт бор, Улаанбаатар Замын Үүд чиглэлийн авто замын дагуу 1,1 га талбай болон 1-р хорооны ногооны талбайд 0,27га талбайд 1000ш агч мод тарьсан. Хэрэгжилтийн хувь 90	90	90
68	Арга хэмжээ 3.7.13. нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн гэрэлтүүлгийн засвар, үйлчилгээ, арчлалтыг хийж гүйцэтгэх.	-	Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн гэрэлтүүлэг Асалт (хувь) Засварласан, шинээр нэмэгдүүлсэн гэрэлтүүлэг	930 100 21	Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн 930ш гэрэлтүүлгийн засвар үйлчилгээг тогмол хийж, Замчин гэр хороллолд 6ш, Үнэгтэй гэр хороололд 7ш, Бор-Үзүүрийн гэр хороололд 5ш, Нуурын гэр хороололд 3ш гэрэлтүүлэг сольж, 1-р хорооны 2,4-р байрраны дээр СОЁЛТОЙ-ИРГЭН, ТОХИЛОГ - ОРЧИН үсгэн гэрлийг шинээр хийж байршуулсан. Гэрэлтүүлгийн асалтыг 100% -д барьж ажиллаж байна. Хангай -1,2 паркт орчин үеийн шийдэл бүхий усан оргилуурдыг ажиллагаанд оруулж, гэрэлтүүлгийг нэмэгдүүлэн ажиллаж байна.	100	100
3.8.Хотын стандартын хүрээнд:							
69	Арга хэмжээ 3.8.1. стандарт, норм, дүрэм мөрдүүлэх талаар аж ахуйн нэгж, байгууллага, Сууц	-	Стандартын хэрэгжилт, хувь	100	Дүүргийн сууц өмчлөгчдийн холбоод 5 сард Налайх дүүрэгт "Хотын стандартын нэвтрүүлэх" сургалтад Хангай өргөө СӨХ-ын 2 ажилтан сургалтанд хамрагдсан.	70	70

	Өмчлөгчдийн Холбоо, дүүрэг, хороодын албан хаагчдыг хотын стандартын сургалтад хамруулах ажлыг Хот байгуулалт, хотын стандартын газартай хамтарч зохион байгуулах;	-	Сургалтад хамрагдсан албан хаагчид	2	Хэрэгжилтийн хувь 70		
70	Арга хэмжээ 3.8.2. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжтэй байдлыг хотын стандартын дагуу хангуулах, аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчин, гудамж зам талбайг засварлаж тохижуулах ажлыг зохион байгуулах;	-	ХБИ-ийн хүртээмжтэй байдлыг хангах хүрээнд тохижуулсан талбайн хэмжээ, $м^2$	50	Дүүргийн 2 дугаар хороонд Нийслэлийн Засаг даргын А/560 дугаар захирамжийн хүрээнд хороодын тохижилтын ажлын дагуу "Ахмадын төгөл" нийтийн амралтын зориулалттай газарт 50 метр урт, 1.5 метр өргөнтэй, нийт 60 $м^2$ талбай бүхий явган замыг UCS0901B стандартын шаардлагын дагуу барьж ашиглалтад оруулаа. Хэрэгжилтийн хувь 100	100	100
71	Арга хэмжээ 3.8.3. тохижилт бүтээн байгуулалтын ажилд (хүүхдийн тоглоомын талбай, явган зам, унадаг дугуйн зам, худалдаа үйлчилгээний газрын гадна орчин, хог хаягдал, ногоон байгууламж) зөвлөмж арга зүйгээр хангах, хяналт шалгалтын үйл ажиллагаанд холбогдох байгууллагатай хамтран ажиллах;	-	Зөрчлийн арилгалт, хувь	100	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/237, дүүргийн Засаг даргын А/47 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн 1, 2 дугаар хороонд 'Орчны аюулгүй байдлыг хангах' үзлэг, шалгалтыг 4 удаа зохион байгуулав. Хүүхдийн нэгдсэн тоглоомын талбайн аюулгүй байдлыг тогтмол хянах үед нийт 90 зөрчил илэрсэн бөгөөд тэдгээрээс 87 зөрчлийг газар дээр нь арилган ажилалаа. Харин үлдсэн 3 зөрчил нь хөрөнгө мөнгө, цаг хугацаа шаардах тул шат дараатайгаар шийдвэрлэхээр байна. Хэрэгжилтийн хувь 96,6	96,6	96,6
			Зохион байгуулсан хяналт шалгалт	3			
			Илрүүлсэн зөрчил	30			
72	Арга хэмжээ 3.8.4. дүүргийнхээ хэмжээнд хотын стандартыг мөрдүүлэх арга хэмжээний үр дүнг нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2025 оны эхний хагас жилд багтаан Хот байгуулалт, хотын стандартын газартай хамтарч танилцуулах.	-	Арга хэмжээний хэрэгжилт	90	Дүүрэгт 2025 онд Улс, Нийслэл, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон дүүргийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй ажил, арга хэмжээний ажлын даалгаварт хотын стандартыг мөрдөж ажиллах шаардлагыг тавьсан. Энэ хүрээнд UCS002-02:2019, UCS2101A:2020, UCS1507C:2020, UCS1406B:2022, UCS1706A:2022, UCS0301B:2019, UCS1001:2023, UCS1409B:2022, UCS1405B:2022, UCS1102B:2022, UCS0901B:2022, UCS0802A:2022, UCS1409C:2022 зэрэг холбогдох стандартыг ажлын явцад бүрэн хэрэгжүүлэхийг шаардлага болгон ажиллаж байна. Хэрэгжилтийн хувь 50	55,5	55,5
73	Арга хэмжээ 3.8.5. Нийслэлийн хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хотын стандартыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, мэдлэг ойлголтыг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулан ажиллах.	-	Арга хэмжээний хэрэгжилт	100	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газраас "Хотын стандартын сургалт, танилцуулга" сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулав. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд хот нэгдсэн стандарттай байхыг тусгасны дагуу иргэд эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн 16 бүлгийн 68 стандартын хэрэгжилтийг танилцуулсан.Уг сургалтад дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчид болон дэд бүтцийн байгууллагын инженер,	100	100

					техникийн 29 ажилтан хамрагдаж, ажлын байрандаа мөрдөх шаардлага, стандартын хэрэгжилтийг хангах, иргэдэд сурталчлан таниулах арга зүйн мэдлэгийг олгосон чиглүүлэх сургалт болсон. Хэрэгжилтийн хувь 100		
3.9.Бусад:							
74	Арга хэмжээ 3.9.1. энэхүү гэрээний 2.1.5-д заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах;	-	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт	100	Тайлангийн хугацаанд дараах бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг ханган дээд газарт хэрэгжилтийг тайлагнасан. Үүнд: - Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээнээс дүүрэг хариуцан хэрэгжүүлэх (9.3.2. Улсын кадастрын мэдээллийн нэгдсэн системд холбогдож, хэрэглээнд нэвтрүүлэн, гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийг шинэчлэн, хэрэглээнд нэвтрүүлсэн байна. 9.8.2. Нийтийн зориулалтай орон сууцны барилгын дээврийг засварласан байна. 9.19.4. Сул шороон хөрсийг явган зам, талбай болгон тохижуулна.) нийт 3 арга хэмжээг түүвэрлэн хэрэгжилтийг ханган ажилласнаас хяналт-шинжилгээний дундаж үнэлгээ 95 хувьтай "үр дүн гарсан" гэж үнэлэгдэв. - Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнөөс дүүрэг хариуцан хэрэгжүүлэх нийт 15 арга хэмжээг түүвэрлэн жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийг ханган ажиллалаа. Тус бодлогын баримт бичгээс хяналтад авагдсан арга хэмжээнээс үр дүнтэй-10, үр дүн хүлээгдэж байгаа-1, үр дүн хангалттүй-2, үр дүн гараагүй-0, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй-2 арга хэмжээ байна. Хяналт-шинжилгээний ерөнхий үнэлгээ 87,4 хувьтай "Үр дүнтэй" гэж үнэлэв. - "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-өөс дүүрэгт хамаарах 22 арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнахаар бодлогын хэлтсүүдээс авч нэгтгэж байна. Хэрэгжилтийн хувь 70	70	70
75	Арга хэмжээ 3.9.2. Дүүргийн Засаг дарга нь энэхүү гэрээний 5.2, 5.3-т заасан хугацаанд гэрээний хэрэгжилтийн тайланг ирүүлэх;	-	Тайлан, биелэлт хүргүүлсэн давтамж	2	Гэрээний биелэлтийн хагас жилийн тайланг 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн, бүтэн жилийн тайланг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хяналт-шинжилгээ хийж, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэх чиглэлийн хэрэгжилтийг ханган 2025 оны жилийн эцсийн тайланг нэгтгэн, Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн биелэлтийн хамт хүргүүлэв. Хэрэгжилтийн хувь 100	100	100
76	Арга хэмжээ 3.9.3. төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулах	-	Сургалтад хамрагдсан	200	Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны А/06 дугаар тогтоолоор Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл,	90	90

	чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга, хариуцлагыг шалгуур болгох;	-	албан хаагчид Сургалтын төрөл, давтамж	24	нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд дүүргийн Засаг даргын 2025 оны А/84 дүгээр захирамжаар 2 зорилт 12 арга хэмжээтэй төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд Төрийн албан хаагчдын мэдлэг, мэргэшил ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтуудыг үе шаттай зохион байгуулан нийслэл, яам, агентлаг, удирдлагын академи, хүний нөөцийн хөгжлийн төвтэй хамтран жилийн эцсийн байдлаар нийт давхардсан тоогоор 15 аж ахуйн нэгж байгууллагын 1521 албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэн ажилласан бөгөөд Улсын төсвийн болон байгууллагын зардлаар удирдлагын академийн төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг мэргэшүүлэх богино хугацааны сургалтад 2 албан хаагч, дунд хугацааны сургалтад 8 албан хаагч, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 5 албан хаагч, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 4 албан хаагч нийт 19 албан хаагч тус тус хамрагдлаа. Дүүргийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн А/117 дугаар захирамжаар Аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарын 2025 оны ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний багийг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулласан. Үнэлгээний багт нийт 26 байгууллага 2025 оны гүйцэтгэлийн тайлан ирүүлж, 8 шалгуур үзүүлэлтээр нийт 100 оноогоор үнэлж дүгнэлээ. Төсвийн шууд захирагчийн хандлага ёс зүйг үнэлэхдээ дүүргийн Цагдаагийн хэлтсээс ирүүлсэн гэмт хэрэг, зөрчилд холбогдсон байгууллагын албан хаагчийн тоон судалгааг үндэслэн гэмт хэрэг, зөрчлийн тоо бүрээр 1 оноо хасаж тус тус үнэлж дүгнэлээ. Хэрэгжилтийн хувь 90		
77	Арга хэмжээ 3.9.4. төрийн албан хаагчийг томилохдоо "Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам", "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын зохицуулалтын дагуу зохист хэлбэрүүдийг ашиглан хууль зөрчихгүй ажиллах, зөрчсөн тохиолдолд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээх;	-	Хууль, журмын хэрэгжилт	100	Төрийн албан хаагчийг томилохдоо "Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам", "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын зохицуулалтын дагуу Хөдөө аж ахуйн тасгийн Хүнсний ногоо үйлдвэрлэл, малын тэжээл ханган, байгаль хариуцсан мэргэжилтнийг Архангай аймгийн Батцэнгэл сумын Засаг даргын Тамгын газрын Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтнээр, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн Нийгмийн халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнийг Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгийн Хүнсний ногоо үйлдвэрлэл, малын тэжээл ханган, байгаль хариуцсан мэргэжилтнээр Тохижилт, худалдаа, үйлчилгээний хэлтсийн Дэд бүтэц, сөх нийтийн тээвэр хариуцсан мэргэжилтнийг Нийтийн тээврийн бодлогын газрын Авто тээвэр хяналтын улсын	90	90

					байцаагчаар, 1-р хорооны Зохион байгуулагчийг Хотын стандарт, тохижилт нийтийн аж ахуйн хэлтсийн Дэд бүтэц, тохижилт, орчны бохирдол хариуцсан мэргэжилтнээр, Нийгмийн хөгжлийн хэлтсийн Боловсрол, соёл урлаг хариуцсан мэргэжилтнийг 415 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн холбоо, мэдээллийн технологийн инженерээр нийт 5 албан хаагчийг Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.5 дахь хэсэгт заасны дагуу шилжүүлэн томилон ажиллалаа. Хэрэгжилтийн хувь 90		
78	Арга хэмжээ 3.9.5. төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулах;	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	100	Төрийн байгууллагын хүнд суртлыг багасгах, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд үйл ажиллагаагаа сурталчлах "Нээлттэй хаалга"-ны өдөрлөг арга хэмжээг 1 удаа зохион байгууллаа. Арга хэмжээнд олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар төрийн байгууллага, ААНБ-ын хүлээх үүрэг, хориглох зүйл", "Авлигын тухай болон албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг мэдэгдэх", "Нийтийн албан тушаалтан, Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах албан тушаалтны тухай ойлголт, анхаарах асуудал" 3 төрлийн гарын авлага бэлтгэн 34 ш, Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчлах 9 төрлийн гарын авлага 24 ш, плакат 13 ш, стейкэр 36 ш-ийг тус тус бэлтгэн иргэдэд тарааж зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллав. Мөн өдөрлөгийн үеэр "Авлигын индекс ба шударга байдлын үнэлгээг нэмэгдүүлэх" чиглэлээр санал асуулга бэлтгэн иргэдээс санал авч ажиллалаа. Мөн "Авлигын тухай мэдэгдэх", "Албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг мэдэгдэх" тухай 2 төрлийн видео контент, "Үгүй гэж хэлээд, зөвийг бүтээе" постер бэлтгэн дүүргийн bagakhangai.ub.gov.mn веб сайт, байгууллагын фейсбүүк хуудсуудаар сурталчлан ажиллалаа. Дүүргийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд оролцогч 25 байгууллагад Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчлах 5 төрлийн 125 ш плакат, 3 төрлийн 250 ш стейкэр тарааж авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллалаа. ХАСХОМ-ийн 2024 оны тайлан гаргах мэдээлэл, зөвлөгөөг 2 ЭБАТ, ХАСХОМ шинэчлэн гаргасан 24, шинээр томилогдсон 11 албан тушаалтанд ХАСУМ болон ХАСХОМ гаргах арга зүйн зөвлөгөөг өгөн ажиллав. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан "ХАСХОМ, ХАСУМ-	90	90

					ийг бүрттэх, хянах, хадгалах, ХАСХОМ гаргах эрх албан тушаалтны жагсаалт гаргах, тайлагнах, мэдэгдэл, тайлбар гаргах" сургалт 2, "2024 оны Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг шинэчлэн гаргах" сургалт 2, "Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийн тухай ойлголт" цахим сургалтуудыг зохион байгуулан 7 ЭБАТ, 54 ХАСХОМ гаргах албан тушаалтан 141 төрийн болон үйлчилгээний албан хаагчдыг хамруулласа. Хэрэгжилтийн хувь 90		
79	Арга хэмжээ 3.9.6. дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагааны үр дүнд үнэлгээ өгсөн ажлын хэсгээс хүргүүлсэн зөвлөмж, дүгнэлтэд заагдсан ажлыг тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлж хагас, бүтэн жилээр тайлангийн хамт, үр дүнг нь үнэлэн нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээний газарт ирүүлэх;	-	Зөвлөмж, дүгнэлтийн хэрэгжилт	100	Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай" А/61 дүгээр захирамжаар 2024 оны ажил дүгнэх ажлын хэсэг томилогдон дүүрэгт ажилласан болно. Зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлэх 9 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Төлөвлөгөөний хэрэгжилт 100%-тай хэрэгжсэн байна. Хэрэгжээгүй болон хугацаа болоогүй заалт байхгүй байна. Хэрэгжилтийн хувь 100	100	100
80	Арга хэмжээ 3.9.7. Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгоор Багахангай дүүргийн хүн амын тоог 20 хувиар нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг баримталж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах;	-	Хууль тогтоомжийн хэрэгжилт	100	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны Хот хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 419 дүгээр тогтоолын 4 дэх хэсэгт заасны дагуу дүүргийн Засаг даргын 2023 оны А/64 дүгээр захирамжаар "Хот хөдөөгийн сэргэлт"-ийн бодлогын хэрэгжилтийг хангах Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн зүгээс тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд дараах ажил, арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа. Үүнд: 1.Шилжин суурьшигч иргэдийн амьдрах орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд: - Дүүргийн 2 дугаар хороонд Юнайтед хэрэйд ХХК 6 давхар, 2 блок 96 айлын орон сууцны эхний блок 48 айлын орон сууцыг 2025 оны 11 дүгээр сард ашиглалтад оруулсан. - НОСК-аас санхүүжилтийг шийдвэрлэн хэрэгжүүлж буй дүүргийн 2 дугаар хороонд баригдах 1,2 тэрбум төгрөгийн өртөгтэй 8 айлын орон сууцны байрны ажлын гүйцэтгэгчээр "Жавхлант хүслэн" ХХК шалгарч, 2025 ондоо багтаан хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. - "Монгол чех металл" ХХК-тай хамтран дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 9 давхар 6 блок бүхий нийт 270 айлын орон сууц барих ажил нь бичиг баримт боловсруулалт, холбогдох зөвшөөрлийн шатандаа байна. 2024 онд тус компанийн барилга барих талбай	30	30

					буюу эзэмшил газрын байршил өөрчлөх, шилжүүлэх асуудалд дүүргийн Засаг даргын зүгээс дэмжлэг үзүүлж холбогдох шийдвэрийг гаргасан. 2.Шилжин суурьшигч иргэдэд дүүрэг, орон нутгийн онцлогийг сурталчлан таниулах, мэдээ мэдээллээр хангах ажлын хүрээнд: Дүүрэгт түр оршин сууж байгаа болон шилжин ирж амьдарч байгаа иргэдийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулаа. - Тус уулзалтаар дүүрэг орон нутгийнхаа анхны үүслээс эхлэн өнөөдрийн нөхцөл байдлын талаарх танилцуулгыг хийсэн бөгөөд дүүрэгт үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, албан байгууллагууддаа танилцуулж цаашид Багахангай дүүргийн хөгжлийн төлөвлөлт болох "Багахангай 2040" бодлогын баримт бичгийн талаар иргэдэд Засаг дарга А.Сүхболд танилцуулав. Мөн энэ үеэр хүрэлцэн ирсэн иргэдийнхээ сэтгэгдэл, санал хүсэлтийг сонсож шат шатны байгууллагуудад уламжлан ажиллах болон цаашид хэрэгжүүлж ажиллах талаараа дурьдлаа. - 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр 2 дугаар хорооны УБ-Чойр чиглэлийн босоо тэнхлэгийн улсын чанартай авто зам дагуу байрлах 5х9 буюу 45м^2 хэмжээтэй самбарт "Нэлттэй Багахангай" мэдээлэл сурталчилгааг байршуулан зорчигч, иргэдэд дүүрэгт шилжин суурьших таатай боломж нөхцөлийн талаарх мэдээллийг түгээсэн ба тус ажилд 1,2 сая төгрөг зарцуулсан. - Дүүргийн веб сайтад "Нэлттэй Багахангай" цэс шинээр үүсгэн, дүүргийн үүсэл хөгжил, төр, хувийн хэвшлийн байгууллагуудын нэлттэй ажлын байрны мэдээлэл, газар зохион байгуулалтын мэдээллийг оруулаад байна. 3.Дүүрэгт шилжин ирснээр эдлэх боломж нөхцөлүүд: - "Төрийн албаны тухай" хуулийн 51.3 дахь хэсэгт Сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох заалтын хүрээнд тус дүүргийн Төрийн захиргааны 7 байгууллагын нийт 61 албан хаагч тус урамшуулалд хамрагдаж 302,5 сая төгрөгийг олгоод байна. - Дүүргийн Хаан банкинд 5 иргэн, Төрийн банкинд 3 иргэн орон сууцны ипотекийн зээл судлуулж, 5 иргэний зээлийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн бөгөөд зээл хүсэгч иргэдийн хувийн байдлаас шалтгаалан 2 иргэний зээл шийдвэрлэгдэж, 5 иргэний зээлийн эх үүсвэр буцаж		

					татагдсан байна. Түүнчлэн Хот хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, дүүргийн төсвийн орлого, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк ХК-д нэгжээр орсон Сарьдаг хангайн оргил ХХК дүүрэгт шилжин ирээд байна. Хэрэгжилтийн хувь 30		
81	Арга хэмжээ 3.9.8. шилжилт хөдөлгөөний тандах судалгааг хагас жилд хамгийн багадаа 1 удаа зохион байгуулж, мэдээллийг нэгтгэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэх;	-	Зохион байгуулсан тандах судалгаа	1	Дүүрэг доторх шилжилт хөдөлгөөн 2023 онд хамгийн өндөр үзүүлэлттэй, 2025 онд хамгийн бага үзүүлэлттэй байна. Хөдөөнөөс шилжин ирэх шилжилт хөдөлгөөн харьцангуй тогтвортой байна. 2025 оны байдлаар хөдөөнөөс ирсэн том хүн 58 (хүүхэд 31), бусад дүүргүүдээс ирсэн том хүн 46 (хүүхэд 37), дүүрэг дотор шилжин ирсэн там хүн 33 (23) байна. Тайлангийн хугацаанд Хэрэгжилтийн хувь 90	90	90
82	Арга хэмжээ 3.9.9. сайн засаглалыг хөгжүүлэх, цахим засаглалыг нэвтрүүлэх, дотоод удирдлага хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор MNS ISO 9001:2016 стандартыг нэвтрүүлэх;	-	Нэвтрүүлсэн стандартын хэрэгжилт	100	Орон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж, менежментийн сайн түвшинд хүрэх, сайн засаглалыг бий болгох, төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээний үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор "Менежмент ба ур чадварын хүрээлэн" ТББ, "Глобал Куалити" ХХК-тай хамтран ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны стандартыг байгууллагад нэвтрүүлж 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр баталгаажилтын гэрчилгээгээ гардан авлаа. Чанарын менежментийн тогтолцооны стандартыг дүүргийн хэмжээнд хэрэгжүүлэх, байгууллага хооронд туршлага солилцох, шаардлагатай модуль сургалтуудыг зохион байгуулах, төсөл хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлэх зорилгоор "Хамтын ажиллагааны Санамж бичиг"-т Дүүргийн Засаг дарга А.Сүхболд, "Менежмент ба ур чадварын хүрээлэн" ТББ-ын Захирал Т.Мөнгөнбөгж нар гарын үсэг зурлаа. Хэрэгжилтийн хувь 90	90	90
83	Арга хэмжээ 3.9.10. холбогдох хууль тогтоомжоор эрх олгосон тохиолдолд захиргааны хэм хэмжээний акт боловсруулж, батлан Нийслэлийн Засаг даргаар дамжуулан Хууль, зүй дотоод хэргийн яаманд бүртгүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;	-	Батлагдсан захиргааны хэм хэмжээний акт	-	Тус хугацаанд дүүргийн зүгээс Хууль, зүй дотоод хэргийн яаманд бүртгүүлсэн хэм хэмжээний акт байхгүй болно.	-	1
84	Арга хэмжээ 3.9.11. Дүүргийн Засаг дарга нь гэр хорооллоос үүдэлтэй	-	Үйл ажиллагааны	-	Тус дүүрэг агаарын чанарыг сайжруулах бүсэд хамаардаггүй болно.	-	-

	агаарын бохирдлын эх үүсвэрийг бууруулах, байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийн хэрэглээг нэмэгдүүлэх тухай төсөл, төлөвлөгөө боловсруулж, үр дүнтэй ажлыг зохион байгуулах.		хэрэгжилт				
85	Арга хэмжээ 4.1.1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу улс, нийслэлийн хөгжлийн төлөвлөгөөнд санал боловсруулж ирүүлэх;	-	Боловсруулж хүргүүлсэн санал	31	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны 05-01/7594 дүгээр албан бичгийн дагуу Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд тусгуулахаар нийт 5 арга хэмжээг тайлбар, үндэслэлийн хамтаар Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт заасны дагуу улс, нийслэлийн урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн холбогдох заалтуудтай уялдуулан боловсруулж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 03/26 дугаар албан бичгээр НЗДТГ-т хүргүүлж ажиллалаа. Мөн "Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д санал ирүүлэх тухай албан бичгийг үндэслэн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 04/581 дүгээр албан бичгээр дүүргийн харьяа байгууллагуудаас саналыг авч нэгтгэн нийт 18 саналыг холбогдох газарт хүргүүлсэн. Түүнчлэн нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 05-01/4290 дүгээр албан бичгээр ирүүлсэн Нийслэлийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд санал ирүүлэх тухай албан бичгийн дагуу харьяа байгууллагуудаас холбогдох саналыг авч нэгтгэн нийт 8 саналыг холбогдох газарт хүргүүлсэн. Хэрэгжилтийн хувь 100	100	100
86	Арга хэмжээ 4.1.2. Улс, нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь чанартай гүйцэтгэж, үр дүнг нийслэлийн Засаг даргын өмнө хариуцах;	10,321.1	Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажлын гүйцэтгэл, хувь	100	Улс, нийслэл дүүргийн төсвийн хөрөнгөөр 2025 онд 29 төсөл хөтөлбөр арга хэмжээний 11,286.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж байна. Одоогийн байдлаар нийт гүйцэтгэл 97.1 хувьтай байна. Үүнд: - Спорт заалны барилга, - Тусгай чиг үүргийн байгууллагуудын бие бүрэлдэхүүний дадлага, сургалт хийх талбай, - Замчин нуурын гэр хорооллын "Дэд бүтцийн төв"-ийн гадна инженерийн хангамжийн шугам сүлжээ, - Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн барилга, Дүүрэгт НЗД-аас эрх шилжин ирсэн 3 ажил, он дамжин хэрэгжиж буй 2 ажил нийт 4,198.2 сая төгрөгийн ажлын гүйцэтгэл нийт 100.0 хувьтай байна. - Соёлын ордны барилга /БХД, 1-р хороо/ - Хойд жигүүрийн халаалт болон хэрэглээний халуун усны шугам сүлжээ (Багахангай дүүрэг, 1 дүгээр хороо) - Ерөнхий боловсролын 94 дүгээр сургуулийн спорт заал	97,1	97,1

					болон шалны засварын ажил, - Ерөнхий боловсролын 91 дүгээр сургуулийн барилгын засварын ажил, - Авто зам замын байгууламжийн засвар, арчлалт, шинэчлэл Жилийн эцсийн байдлаар 3 ажилд хяналт тавих Ажлын хэсэг байгуулагдан нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын захиалагчийн хяналтын албаны гишүүдтэй 6 удаа хяналт хэрэгжүүлэн ажиллалаа. Төрийн Худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/ сайтад 2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хуулийн хугацаанд шивж баталгаажуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ОНХС-гийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр арга хэмжээний саналыг гар утасны апплекейшн, цахимаар хэрхэн авах тухай мэдээллийг 4 удаа хүргүүлсэн. Дүүргийн төсвийн хөрөнгө болон ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 5 ажлын 387,6 сая төгрөгийн санхүүжилт олгон зарцуулалтын мэдээллийг shilendans.gov.mn, бусад цахим сайтад байршуулав. Дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 23 төсөл, арга хэмжээ төлөвлөгдсөнөөс жилийн байдлаар 24 үнэлгээний хороог хууль, журмын дагуу байгуулж, давхардсан тоогоор 120 албан хаагч, иргэн ажиллав. Үнэлгээний хорооны гишүүдээр "Ашиг сонирхлын мэдүүлэг" бөглүүлэн shilendans.gov.mn, tender.gov.mn, meduuleg.iiac.mn болон бусад мэдээллийн сувгуудаар ил тод нээлттэй мэдээлж байна. Хэрэгжилтийн хувь 100		
87	Арга хэмжээ 4.1.3. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангаас дүүрэгт 440,000,000 (дөрвөн зуун дөчин сая) төгрөгийг эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилгын хөрөнгө оруулалт, их засварын ажлын төсөл арга хэмжээг Орон нутгийн хөгжлийн сангийн журмын дагуу зохион байгуулж хэрэгжүүлэх;	440,000.0	Хөрөнгө оруулалт, их засварын ажлын гүйцэтгэл	100	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/186 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан 440,000,000.0 (дөрвөн зуун дөчин сая) төгрөгийн "Эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилгын хөрөнгө оруулалт, их засварын ажил (Улаанбаатар хот, Багахангай дүүрэг)"-ыг БАГЦ-1 буюу "Ерөнхий боловсролын 91 дүгээр сургуулийн барилгын засварын ажил", БАГЦ-2 буюу "Ерөнхий боловсролын 94 дүгээр сургуулийн спорт заал болон шалны засварын ажил" гэсэн 2 багцад хөрөнгийг хуваж тендер шалгаруулалтыг зохион байгуулсан. Хэрэгжилтийн хувь 90	90	90
Хяналт-шинжилгээний дундаж үнэлгээ					92,5% "Үр дүн гарсан"		

Нийт 87 арга хэмжээг хяналтад авч, хэрэгжилтийг ханган ажилласнаас үр дүн гарсан 70, үр дүнгүй 17 арга хэмжээ байна.

Хяналт-шинжилгээний ерөнхий үнэлгээ 92,5 хувьтай "Үр дүн гарсан" гэж үнэлэв.

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГА А.СҮХБОЛД

ХЯНАСАН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Л.САНЖИЙЖАМЦ

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Б.ОТГОНЖАРГАЛ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН
ЭРХ ЗҮЙ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Н.БАТЦЭНГЭЛ

ХЭРЭГЖИЛТ ТАЙЛАГНАСАН
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Б.ОДБАЯР